Хамгийн чухал нь төсвийн тодотгол

2017 оны төсвийн тодотголыг хаврын чуулганаар хэлэлцэх боломжтой. >2

Барилгын компаниуд СӨХ байгуулж болохгүй

Сууц өмчлөгчдийн 1022 холбооны 881 нь нийслэлд үйл ажиллагаа явуулж байна. >4

Эрүүл амьдрах 1000 боломж

Үсэрч, цовхчихгүй тайван аргаар турахыг хүсэж байгаа хүмүүс балет, йог сонгох нь зүйтэй. >7

20 жил MobiCom
MobiCom

NNC NATIONAL NEWS CORP | БҮРЭЛДЭХҮҮН КОМПАНИ

ZASAG.CO

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.03.16, ПҮРЭВ ~ №048 (594)

ҮНЭ: 600₮

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Гамшгийн үед бусдыг аврах талаар ЕБС-д хичээл заах хэрэгтэйг Ерөнхийлөгч онцлов.

Засгийн газар зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлнэ.

УИХ-ын гишүүд ХБНГУ-д айлчилж, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн Ажлын хэсэг хуралдлаа.

ЭДИЙН ЗАСАГ

Хөрөнгийн биржийн индекс 851.17 нэгж болж, 0.33 хувиар буурав.

"Эрдэнэс Тавантолгой" компани "Монгол уурхайчид" түншлэлтэй хамтран ажиллана.

"Mongolia Gold 2017" алтны салбарын хөрөнгө оруулалтын хурал маргааш болно.

Нүүрснээс нийлэг хий үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ирэх сард танилцуулна.

"Мон наб" хувьцаат компанийн үнэт цаасыг бууруулж, гуравдугаар ангилалд бүртгэв.

НИЙГЭМ

Зэвсэгт хүчний 96 жилийн ойг угтан Батлан хамгаалахын багц хуулиудыг танилцууллаа.

Куба улстай хамтран хачигт халдварын вакциныг мал, амьтанд тарих судалгаа хийнэ.

Дугуй, хуванцар хог хаягдал шатаах нь мэдрэлийн системд сөргөөр нөлөөлдгийг тогтоов

Судалгаанд хамрагдсан 10 хүүхэд тутмын найм нь хүчирхийлэлд өртдөг гэжээ.

Увсын 500 гаруй айл үерт автах эрсдэлтэй байгааг ОБЕГ-аас мэдээлэв.

Агаар бохирдуулсан 27 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох шаардлага хүргүүлэв.

ДЭЛХИЙ

Трампын татварын тайланг нийтлэсэн нь хууль бус үйлдэл гэж Цагаан ордон үзлээ.

БНХАУ АНУ-тай худалдааны дайн өрнүүлэх хүсэлгүй болохыг Ли Кэчян мэдэгдэв.

Өмнөд Солонгос тавдугаар сарын 9-нд Ерөнхийлөгчийн сонгууль явуулна.

Путин, Эрдоан нар Туркт С-400 систем нийлүүлэх талаар хэлэлцлээ.

Японд химийн шинэ элементийг "Нихониум" гэж нэрлэх ёслолын ажиллагаа болов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.03.16

5° -7°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Салаагаар урсаж буй саарал ус



Нийслэлчүүдийн усны хоногийн хэрэглээ 180 мянга гаруй шоо метр. Үүний 51.4 хувь нь дахин ашиглах боломжтой буюу саарал ус гэдгийг салбарын мэргэжилтнүүд тогтоосон байна. ▶5

ВВМ©

FT FINANCIAL TIMES Өглөгийн эзэд боловсролд анхаарлаа чиглүүлж байна

Жэймс Кинжи

Хорвоо ертөнцийн олон асуудлаас ганц нь л онц ноцтой хэмээн Хятаддаа хоёрдугаарт ордог филантроп, 2016 онд 615 сая ам.долларыг буяны хандивт зориулсан Чен И-Дань өгүүлэв. Манай гарагийн залуусын гуравны нэг нь ажил, сургууль ч үгүй өдөр хоногийг өнгөрөөж байгаад тэрбээр сэтгэл зовнидог ажээ.

Залуу үеийнхэнд нүүрлэсэн энэхүү баргар нөхцөл хөгжингүй юм уу хөгжиж буй орнуудын аль нэгийг гэлгүйгээр, нийтэд нь хамрах хандлагатай болоо. Дэлхийн 15-24 насны залуучуудын 13 хувь нь ажилгүйчүүдийн эгнээнд нэгдэж болзошгүй, нийт залуусын гуравны нэг нь боловсрол, сургалт, ажил хөдөлмөрийн аль нэгэнд хамрагдаж чадахгүй байгааг Economist Intelligence Unit-ийн (EIU) судалгаа харуулаа. Энэ үзүүлэлт жил бүр 45 саяар нэмэгдэж байна.

"Технологийн дэвшил нь хүмүүс цалин авч гүйцэтгэдэг ажил хөдөлмөрийн 45 хувийг удахгүй автоматжуулах төлөвтэйг EIU-гийн судалгаа баталж байна" хэмээн Хятадын интернэт, гэймингийн аварга Tencent компанийг үндэслэгч Чэн овогт өгүүлэв.

▶9

ЗГМ: ИНФОГРАФИК



НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Бондын хаялга

Мөнгөний урсгалын чиг өөрчлөгдөж, хөрөнгийн зах зээлийг "онилов"

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Засгийн газрын богино хугацаат үнэт цаас буюу бондыг хөрөнгийн биржээр арилжаалж эхлээд багагүй хугацаа өнгөрч байна. Төсвийн алдагдал, улирлын чанартай орлогын цоорхойг зээлээр босгож байгаа нь энэ. Цалин, тэтгэвэр, нийгмийн хамгааллын зарим зардлыг үнэт цаас гаргах замаар төр нөхдөг. Энэ жишгээр өнгөрсөн хугацаанд олон удаагийн хүндрэлийг давсан. Засгийн газрын тодотголтой төгрөгийн өрийн бичиг дотоодын зах зээлд хамгийн эрэлт ихтэй байна. Эрсдэл багатай, тогтмол орлоготой өрийн бичгийн захиалга энэ сард илүү идэвхжлээ. Иргэд өгөөжтэй хөрөнгө оруулалтын үнэ цэнийг цаг алдалгүй хүртэхээр шимтэж байна.

Хөрөнгийн зах зээлийн энэ долоо хоногийн хамгийн өндөр дүнтэй арилжааг мягмар гарагт хийсэн нь Засгийн газрын үнэт цаасны арилжаа байв. Төсвийн алдагдлыг түргэн хугацаанд хаах боломж нь Засгийн газрын баталгаатай үнэт цаас. Засгийн газраас баталгаа гаргадаг учраас эргэн төлөлт нь найдвартай, эрсдэлгүй үнэт цаасанд иргэд хадгаламжаа байршуулах сонирхол нэмэгджээ. Мөн сул хөрөнгөө өсгөх таатай боломжийг бонд олгож байгаа нь энэ.

▶3

ЭДИЙН ЗАСАГ

"Chalco"-гийн өр нимгэрч байна

Г.Байгал
@baigalZGM

"Chalco"-гийн өр нимгэрч байгааг "Эрдэнэс Тавантолгой" компаниас мэдээлэв. Өрийн үлдэгдэл 56 сая ам.долларт хүрснийг компанийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд өнгөрсөн сард мэдэгдсэн юм. Үүлдэгдлийг энэ онд багтаан барагдуулах боломж байгааг компанийн удирдлагууд удаа дараа илэрхийлж байгаа. Ингэснээр сүүлийн зургаан жил дамнаж буй 350 сая ам.долларын их өрөнд цэг тавих нь. Гэхдээ өр төлөөд "Эрдэнэс Тавантолгой", "Chalco"-гийн тохиролцоо дуусахгүй. Гэрээ ёсоор өр төлбөрийг цэглэсний дараа Тавантолгойн Зүүн цанхиас олборлож буй нүүрсний багагүй хувийг "Chalco"-д нийлүүлэхээр тохирчээ. Бас борлуулалтыг зах зээлийн ханшаар хийхээр тусгасан байна.

Эргэн сануулахад, 2011 оны намар Монгол Улсын Засгийн газар Хятадын төрийн өмчит "Chalco" компанид нүүрс нийлүүлэхээр тохирч, урьдчилгаа төлбөр болох 350 сая ам.доллар зээлсэн.

▶11

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
851.17 0.33%	1199.70 0.09%	5820 0.41%	93.546 0.08%	99.450 0.1%	2457.12	355.30	41.69

Улс төр

УЛСЫН ИХ ХУРАЛ

Хамгийн чухал нь төсвийн тодотгол

2017 оны төсвийн тодотголыг хаврын чуулганаар хэлэлцэх боломжтой

Б.Даваатогтох
@datoZGM



Б.Ганбаяр / ЗГМ©

УИХ-ын намрын чуулган завсарлаад багагүй хугацаа өнгөрсөн ч эдийн засгийн хүндрэлтэй энэ үед ээлжит бус чуулганыг хуралдуулахаас өөр аргагүй байдал бий болсныг Сангийн сайд Б.Чойжилсүрэн мэдэгдсэн. Учир нь Монгол Улсын Засгийн газрын Олон улсын валютын сантай хийж буй хэлэлцээр өндөрлөж, 2017 оны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага тулгарсан юм. Гэвч МАН-ын Удирдах зөвлөл хуралдаж, УИХ-ын ээлжит бус чуулганыг хуралдуулахгүй байх улс төрийн шийдвэр гаргасан. Ингэснээр ОУВС-тай хийсэн хэлэлцээрийг тодорхойгүй хугацаагаар хойшлуулахад хүрэв.

Харин УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголыг ирэх хаврын чуулганаар хэлэлцэх боломжтой хэмээн онцолжээ. Тэрбээр "УИХ-ын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах болоход гишүүдийн ирц хангалтгүй байгаа. Тиймээс ирэх дөрөвдүгээр сард хаврын чуулган эхлэнгүүт 2017 оны төсвийн тодотголоо хэлэлцээд Олон улсын валютын сангийн хөтөлбөрт хамрагдаад явах боломжтой" гэв. Өөрөөр хэлбэл, ирэх хаврын чуулганаар хэлэлцэх хамгийн чухал асуудал нь 2017 оны төсвийн тодотгол. Төсвийн тодотгол хийж, нийгмийн халамжийг бууруулж, долоон төрлийн татварыг нэмэгдүүлснээр Монгол Улс ОУВС-гийн тусгай хөтөлбөрт хамрагдах боломж бүрдэх юм.

Үүнээс гадна хаврын чуулганаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр төлөвлөжээ. Гэхдээ өнөөдрийн байдлаар энэхүү хуулийн төсөл бэлэн болоогүй бөгөөд өөрчлөлт оруулах, эсэх нь ч тодорхойгүй байна. Учир нь Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжаар байгуулсан Ажлын хэсэг Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, эсэхийг судалж байгаа бөгөөд эцсийн шийдвэр нь гараагүй юм. Ажлын хэсгийн дүгнэлтээс хамаарч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, эсэх нь тодорхой болно гэсэн үг. Үе үеийн парламент Үндсэн хуульд өөрчлөлт оруулах санал, санаачилга гаргадаг ч үр дүнд хүрээгүй байна. Харин энэ удаагийн парламентад МАН 65 суудалтай байгаа нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах томоохон боломж хэмээн үзэж буй. Тиймээс УИХ дахь МАН-ын бүлгээс УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангаар ахлуулан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, эсэхийг судлах Ажлын хэсгийг ч давхар байгуулаад байгаа юм.

Хаврын чуулганаар хэлэлцэх анхаарал татаж байгаа нэг асуудал нь Казиногийн тухай хуулийн төсөл. Гэхдээ мөн л төсөл нь бэлэн болоогүй. Засгийн газраас боловсруулж, батлуулсан Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт казино байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр тусгасан. Энэ дагуу УИХ дахь МАН-ын бүлгээс УИХ-ын гишүүн Л.Энхболдоор ахлуулан уг хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг хуулийн төслөө эцэслээгүй бөгөөд ирэх хаврын чуулганд өргөн мэдүүлнэ гэдгээ урьдчилсан байдлаар мэдэгдээд буй. Ингэхдээ өмнөх Засгийн газрын боловсруулсан Казиногийн тухай хуулийн төсөлд бага зэргийн засвар оруулж, өргөн мэдүүлэх аж.

Мөн Ерөнхийлөгчөөс санаачлан өргөн мэдүүлсэн Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын тухай хуулийн төслийг хаврын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөжээ. Хоёр парламент дамжиж буй энэхүү хуулийн төслийн хэлэлцэх, эсэхийг өнгөрсөн намрын чуулганаар хийсэн ч УИХ-ын гишүүд улс төрд тогтворгүй байдал бий болно гэсэн шалтгаанаар буцаах хүсэлтийг гаргасан. Энэхүү хуулийн төсөлд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын гишүүд болон УИХ-аас томилдог албан тушаалтнууд, аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчид, Засаг дарга нарт хариуцлага тооцох, эргүүлэн татах эрхийг сонгогчдод нээлттэй болгохоор тусгасан. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад хариуцлагагүйн "зуд" нүүрлэсэн энэ үед төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцох эрх зүйн орчныг бий болгох юм.

Дараагийн хэлэлцэх чухал асуудал бол эрх зүйн шинэчлэлтэй холбоотой хэд хэдэн хуулийн төсөл. Тодруулбал, ирэх долдугаар сарын 1-нээс хэрэгжих эхлэх ёстой Эрүүгийн болон Зөрчлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. Өмнөх парламентаас баталсан дээрх хуулиудад засаж, сайжруулах зүйл бий хэмээн Засгийн газар үзэж, нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулсан.

Түүнчлэн УИХ-ын нэр бүхий гишүүдийн өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхээр жагсаалтад оруулжээ. Сонгууль бүрийн дараа төрийн албан хаагчид солигдож, улс төрөөс хэт хамааралтай болоод байгаа. Энэхүү төслийг баталснаар төрийн албыг улс төрөөс ангид байлгах эрх зүйн орчин бүрдэнэ хэмээн төсөл санаачлагчид тайлбарлаж буй.

Гэхдээ энэ удаагийн хаврын чуулганаас томоохон үр дүн гарахгүй. Учир нь ирэх зургадугаар сард Ерөнхийлөгчийн сонгууль болно. Улс төрийн хүчнүүд сонгуулийн бэлтгэлдээ орж, иргэд сонгогчдынхоо итгэлийг олохын төлөө чармайдаг тул УИХ-ын хууль батлах үндсэн үүрэг цалгардаг тал бий. [ЗГМ]

» Ажлын хэсгийн дүгнэлтээс хамаарч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, эсэх нь тодорхой болно.

» Монгол Улсад хариуцлагагүйн "зуд" нүүрлэсэн энэ үед төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцох эрх зүйн орчныг бий болгох юм.

» Энэ удаагийн хаврын чуулганаас томоохон үр дүн гарахгүй.

ЭШЛЭЛ





-Гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцдэг хууль эрх зүйн орчныг үндсэнд нь шинэчилж байгаа. Тухайлбал, Зөрчлийн тухай, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг цогцоор нь шинэчлэн батална. Ингэснээр долдугаар сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлнэ. Мөн үүнийг дагаад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг ч шинэчлэн батлах юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн эсрэг чиглэсэн, нийгэмд аюултай эрх зүйн зөрчил, гэмт хэргүүдээс алийг нь зөрчил, алийг нь гэмт хэрэгт тооцох, ямар ял шийтгэл ногдуулах зэргээр эрх зүйн орчныг бүхэлд нь шинэчилнэ гэсэн үг. 1998 онд УИХ-аас эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр баталснаар 2002 онд дээр дурдсан хуулиудыг цогцоор нь шинэчилж байсан юм. Үүнээс хойш даруй 15 жилийн хугацаа өнгөрсөн байна.

УИХ-ын гишүүн
Х.Нямбаатар

-Ер нь Ардчилсан намын шинэчлэл гэдэг ганц манай намын бус Монголын улс төрийн амьдралд гарч буй цоо шинэ зүйл юм. Гэтэл шинэчлэгдэх процессыг мөнгөөр шийдэж байгаад харамсаж байна. Ардчилсан нам ард түмэндээ үйлчилдэг нам байх ёстой. Тиймээс ч намын даргаа бүх гишүүдээсээ тодруулж, сунгаа явуулсан. Гэтэл одоо өөрийн гишүүдийг сонгох, сонгогдох эрхийг мөнгөөр үнэллээ. Өнөөдөр 20 гаруй настай залуу зургаан сая төгрөг төлөөд Үндэсний бодлогын хороонд өрсөлдөх боломж бололцоо хэр билээ. Мөнгөтэй хүмүүс өмнөөс нь татварыг нь төлөөд Ардчилсан намын гишүүн болгоод кноп даруулах байдал үүсч болно. Эмэгтэйчүүд зургаан сая төгрөг төлөөд өрсөлдөх боломж ч хомс. Мөнгөөр бүхнийг үнэлж байгаа нь Ардчилсан намыг сүйрэлд оруулахаар байна. Үүнийг зогсоох ёстой. Мөнгөөр ярьдаг, уралдаг байдал хэтэрлээ.

УИХ-ын гишүүн асан
Р.Гончигдорж

ЗАСГИЙН ГАЗАР

Ханбогдод зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барина



Өмнөговийн Ханбогдод зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих шийдвэрийг Засгийн газраас гаргалаа. Хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай гэрээ хэлцэл хийх үүргийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгав.

Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших аж. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр нь жилд нэг сая тонн баяжмал боловсруулах хүчин чадалтай байх бөгөөд 2020 он гэхэд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Ийм хэмжээний баяжмал боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэр нь байршлын хувьд түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, эрчим хүч дамжуулах зардал бага зэрэг давуу талыг харгалзан Оюутолгойн ордын дэргэд Ханбогд суманд байрлах нь тохиромжтой гэж салбарын яам, мэргэжилтнүүд үзсэн байна.

Мөн Засгийн газрын хуралдаанаар Тост, Тосон бумбын нуруу болон Ноён уул орчмын байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоов. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагийг 743058.00 га-гаар баталлаа. Үүнтэй холбогдуулан тухайн газарт олгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг эзэмшигчтэй нь хэлэлцэн тохиролцож цуцлах арга хэмжээ авахыг холбогдох сайд, агентлагийн дарга нарт даалгав. Ингэснээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь хэмжээ 0.4 хувиар нэмэгдэх юм. Тусгай хамгаалалтад авсан газрын хилийг заагийг тогтоохоор санал болгосон газартай хэсэгчилсэн болон бүрэн давхцалтай ашигт малтмалын хайгуулын долоон тусгай зөвшөөрөл байгаа аж.

Харин Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Ноён уул орчмын байгалийн нөөц газрын хилийн заагийг 11187.05 га-гаар, Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сумын нутаг дэвсгэрт орших Ноён уул орчмын түүх, соёлын дурсгалт газрын хилийн заагийг 650.0 га-гаар батлав. [ЗГМ]

ТОВЧХОН

» **АЙЛЧЛАЛ**
УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва, Б.Бат-Эрдэнэ, Д.Гантулга, Д.Цогтбаатар, Б.Ундармаа, Д.Мурат нар ХБНГУ-д албан ёсны айлчлал хийв. УИХ-ын гишүүд айлчлалынхаа хүрээнд Бундестагийн дэд ерөнхийлөгч хатагтай М.Нолл, Бундестагийн Батлан хамгаалахын Байнгын хорооны дарга ноён В.Хэлльмихтэй уулзаж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцжээ.

» **ТОМИЛГОО**
УИХ-ын гишүүн асан Д.Загджавыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдаар томилов. Мөн Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Г.Баттунгалагийг Монгол Улсаас НҮБ-ын Вена дахь салбар болон олон улсын бусад байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр томиллоо.

» **УУЛЗАЛТ**
УИХ-ын гишүүн Б.Баттөмөр ОХУ-ын Төрийн думын Эрүүл мэндийн байнгын хорооны дэргэдэх экспертийн зөвлөл болон Эрүүл мэндийн яамны тамхины хяналтын асуудлаарх зохицуулах зөвлөлийн гишүүн Ольга Вадимовна Кноррег хүлээн авч уулзлаа. Тэрбээр Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийг сайжруулах чиглэлээр ОХУ-ын Эрүүл мэндийн яаманд хамтран ажиллах хүсэлт гаргасан юм байна.

» **НАМУУД**
Ардчилсан намын дотоод сонгуулийг зохион байгуулах хорооноос гаргасан шийдвэрийн дагуу шат, шатны сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдийн бүртгэлийн хугацаа өнгөрсөн лхагва гарагт дууслаа. Ардчилсан намын дотоод сонгуулийн санал хураалт ирэх сарын 2-нд болно. Мөн Улсын дээд шүүхээс Ардчилсан намын даргаар С.Эрдэнийг сонгосныг бүртгэсэн бол тус намын дүрмийг бүртгэхээс татгалзлаа.

» **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**
УИХ-ын гишүүн О.Баасанхүүгийн санаачилгаар "Шинэ төрийн сэргэн мандахуй" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг Төрийн ордонд боллоо. Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн О.Баасанхүү "Шинэ төр, шинэ Үндсэн хуулийн үзэл санаа", Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн "Шинэ төрийн эдийн засгийн асуудлууд", Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ч.Баатар "Төрийн гадаад бодлогын талаарх үзэл санаа, зарчмууд" сэдвээр тус тус илтгэл тавилаа.

» **СУРГАЛТ**
Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд байгнын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад зориулсан сургалт эхэллээ. Сонгуулийн тухай хууль тогтоомжийн талаар хийх ийнхүү сургалт ирэх сарын 3-н хүртэл үргэлжилнэ.

» **ЦУГЛААН**
Ард түмний онц түр зөвлөлөөс оффшор бүсэд данстай төрийн түшээдийг шалган хариуцлага тооцох тухай шаардах бичгийг УИХ-д хүргүүлжээ. Хэрэв шаардах бичгийн хариу ирэхгүй бол энэ сарын 31-нд Сүхбаатарын талбайд тайван цуглаан зохион байгуулах аж.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

› **OPED@ZASAG.CO**

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

Бондын хаялга

Үнэт цаасны захиалга нэмэгдэж, мөнгөн дүн нь 3-4 дахин өсөх болжээ



Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх дотоод нөөц бололцоог Засгийн газрын үнэт цаас олгож байна.

Б.Ганбаяр/ЗГМ©

◀1

Хөрөнгийн зах зээлийн хамгийн өндөр өгөөжтэй бүтээгдэхүүнийг Засгийн газрын өрийн бичиг тэргүүлж явна. Ашиг нь тодорхой, эрсдэл багатай учраас ам.доллараас илүү Засгийн газрын үнэт цаас руу иргэд тэмүүлэх болжээ. Төгрөгтэй харьцах ам.долларын ханш суларч буй. Энэ нь төгрөгөө ам.долларт хөрвүүлсэн иргэнд мэдээж хохиролтой. Тэд ам.долларыг орхиж, бондод "дурлажээ".

Компанийн хувьцаа давамгайлж байсан зах зээлд Засгийн газрын үнэт цаасны арилжаа жин дарсан нь хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулагчдыг улам татав. Тухайн улсын дотоодын үнэт цааснаас Засгийн газрынх нь хамгийн бага эрсдэлтэйд тооцогддог. Тиймээс Засгийн газрынх нь бондын хүү нь хамгийн бага санхүүжилтийн өртгийн хэмжээг зааж өгдөг. Мөн хөрөнгийн зах зээлийн "суурь хүү" гэж үздэг. Сангийн яамнаас хөрөнгийн биржээр дамжуулан Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас буюу бондыг гаргаж эхэлсэн нь иргэн өөрт байгаа хуримтлалаа эрсдэлгүй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд оруулах боломжийг нээсэн юм.

Хөрөнгийн биржид долоо хоног бүр ирж буй Засгийн газрын үнэт цаасны захиалга нэмэгдэж, мөнгөн дүн нь 3-4 дахин өсөх болсон. Үнэт цаасны эрэлт өндөр байх тусам чухамдаа хүү хямдрах учиртай. Энэ нь төсвийн зардалд эерэг нөлөөтэй юм. Төсвийн алдагдал, өрийн хүндрэл нь Засгийн газрын үнэт цаасны хүү өсөх бодит шалтгааны нэг. Бусад улс орнуудын Засгийн газрын бондтой харьцуулахад манай улсын бондын өгөөж хавьгүй өндөр байгаа юм. Засгийн газраар овоглосон энгийн үнэт цаасны нэрлэсэн үнэ нь 100 мянган төгрөг бөгөөд хямдруулсан нь 91.5 мянган төгрөг. Хүүгийн түвшин нь хугацаанаас хамаарч 17-18 хувийн хооронд хэлбэлзэж байна. Долоо хоног бүр арилжаалах Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны хүүгийн хувь хэмжээг зах зээлийн жишиг хүүг үндэслэн Сангийн яам тогтоож байгаа юм. Тухайлбал, хөрөнгө оруулагчдад санал болгож байгаа хоёр жилийн хугацаатай үнэт цааснаас 36 хувийн өгөөж хүртэх боломжтой.

Өндөр хөгжилтэй ихэнх улсуудын Засгийн газрынх нь богино хугацаат бондын хүү жилийн 0-2 хувь л байдаг. Тухайлбал, Герман, Япон, Швейцарь зэрэг улсын богино хугацаат бонд нь хасах хүүтэй. Эдгээр улсын бондын эрсдэл нь бага, зээлжих зэрэглэл нь өндөр, өрийн дарамт бага байгаа нь суурь хүүнд эерэг нөлөө үзүүлж байна. Харин манай улсын хувьд өрийн дарамт өндөр, зээлжих зэрэглэл тааруу байгаа нь Засгийн газрын үнэт цаасны хүү өндөр байхад хүргэж буй.

Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 2017 онд эрчимжиж байгааг эхэнд тэмдэглэсэн. Хэрвээ та бонд эзэмшиж байх хугацаанд мөнгө шаардлагатай болсон тохиолдолд уг бондын хугацаа дуусахыг хүлээх огт шаардлагагүй. Хоёрдогч зах зээлд Засгийн газрын үнэт цаасыг эргүүлэн худалдаж болдог. Мөн хүүгийн орлого нь албан татвараас бүрэн чөлөөлөгддөг. Түүнчлэн тендер болон төлбөрийн баталгаа болгох зэрэг давуу тал ихтэй.

Эдийн засагт эргэлдэж буй мөнгөний урсгал хөрөнгийн зах зээл рүү чиглэх болов. Засгийн газрын санал болгож буй бондын өгөөж хөрөнгө оруулагчдад ихээхэн таалагдаж байна. Тухайн улсын хөрөнгийн зах зээлийн суурь бүтээгдэхүүн болдог Засгийн газрын үнэт цаасны нийлүүлэлт эрэлтээ гүйцэхгүй байх тохиолдол өмнө нь гарч байсан. Өөрөөр хэлбэл, олон нийтийн зүгээс өндөр захиалга ирэх үед уг нөхцөл байдал үүсдэг.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх дотоод нөөц бололцоог Засгийн газрын үнэт цаас олгож байгаа. Засгийн газрын дотоодод гаргасан үнэт цаасны хэмжээ сүүлийн гурван жилийн хугацаанд нийт мөнгөний нийлүүлэлтийн 25 орчим хувьтай тэнцсэн. Төсвийн алдагдал өнгөрсөн онд эрс нэмэгдсэн нь түүнийг санхүүжүүлэх дотоод эх үүсвэрийн хэрэгцээг энэ онд нийт мөнгөний нийлүүлэлтийн 40 орчим хувьд хүргэхээр байна. Өөрөөр хэлбэл, 10 төгрөг тутмын дөрөв нь Засгийн газрын үнэт цаасны эх үүсвэрээр эдийн засагт орж ирэх нь.

Сүүлийн гурван жилийн хугацаанд шинээр гаргасан Засгийн газрын дотоодын үнэт цаасны мөнгөний нийлүүлэлтийн эзлэх хувь дунджаар 30 орчим байгаа юм. Энэхүү хандлага цашид хэвээр хадгалагдах магадлал өндөр байна. "Санхүүгийн тогтвортой байдлын тайлан"-д ирэх жилүүдэд шинээр гаргах Засгийн газрын үнэт цаасны борлуулалтын төлөвлөгөө биелэхгүй байх эрсдэлтэй гэжээ. Манай улсын хувьд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал байгаа юм. Хэрэв дотоодын захад өндөр хүүтэй үнэт цаас санал болгоно гэж үзвэл энэ нь хүүгийн зардлыг өсгөж, дахин санхүүжилтийн эрсдлийг нэмэгдүүлэх, улмаар өрийн дарамтыг өсгөх талтай. Гэхдээ хөрөнгийн бирж ашигтай ажиллах боломж нь Засгийн газрын үнэт цаас болж байна. [ЗГМ]

» Засгийн газрын дотоодод гаргасан үнэт цаасны хэмжээ сүүлийн гурван жилийн хугацаанд нийт мөнгөний нийлүүлэлтийн 25 орчим хувьтай тэнцжээ.

» Тухайлбал, хөрөнгө оруулагчдад санал болгож байгаа хоёр жилийн хугацаатай үнэт цааснаас 36 хувийн өгөөж хүртэх боломжтой.

» Компанийн хувьцаа давамгайлж байсан зах зээлд Засгийн газрын үнэт цаасны арилжаа жин дарав.



Нийгэм

ЗГМ: ТОДРУУЛГА

Барилгын компаниуд СӨХ байгуулж болохгүй



Сууц өмчлөгчдийн 1022 холбоо ажиллаж байгаагийн 881 нь нийслэлд, 141 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Б.Ганбаяр / ЗГМ©

Өнөөгийн мөрдөж буй хуулийг шинэчлэх шаардлагатай

Б.Бямбасүрэн
@byambaZGM

БХБЯ-наас Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох хэлэлцүүлэг зохион байгууллаа.

1997 онд дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль баталж байсан бол 2003 онд СӨХ-ны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байршингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийг баталжээ. Хэлэлцүүлэгт оролцсон ОСНААУГ, ШӨХТГ, УСУГ-ын төлөөлөл Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг өнөөгийн нийгмийн үйл ажиллагаанд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай гэж үзлээ. Энэ үеэр БХБЯ-ны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн О.Энхтуягаас зарим зүйлийг тодруулсан юм.

-Өнөөдөр болсон зөвлөгөөнөөр ямар шийдэлд хүрсэн бэ?

-Манай яамнаас зохион байгуулсан хэлэлцүүлгийн зорилго Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын өмнө тулгамдаж буй асуудлаар харилцан санал солилцох, ойлголцох, байр сууриа нэгтгэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал авахад оршиж байсан. Одоо бид салбарын төлөөллүүдийн үнэтэй санал, санаачилгыг ажил болгоход анхаарна.

-СӨХ-ны төлбөр их өндөр байдаг. Үүнийг яаж зохицуулдаг вэ. Хууль эрх зүйн орчин нь ямар байдаг вэ?

-Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 9.5-д Дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, хамгаалалт, үйлчилгээтэй холбогдсон зардлыг хуваарилах асуудлыг хуралд оролцож буй гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар шийдвэрлэнэ гэж заасан байдаг. Тэгэхээр тухайн барилгад ямар засвар үйлчилгээг тухайн жилд хийх вэ гэдгээс шалтгаалж, төлбөрийн хэмжээ жил бүр харилцан адилгүй байдаг. Оршин суугчид хуулиар хүлээсэн энэхүү үүргээ биелүүлэхэд идэвхтэй оролцох хэрэгтэй.

-Нийслэлийн хэмжээнд хэчнээн СӨХ бүртгэлтэй байдаг вэ?

-Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд Сууц өмчлөгчдийн 1022 холбоо ажиллаж байгаагийн 881 нь нийслэлд, 141 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

-Шинэ орон сууц барьсан газар нь СӨХ-ны үйл ажиллагаа явуулдаг. Энэ тал дээр ямар арга хэмжээ авах ёстой вэ?

-Барилга барьсан компаниуд СӨХ байгуулж байгаа нь хууль зөрчсөн асуудал. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн тавдугаар зүйлийн 5.2-т Орон сууцны нэг байшинд нэг холбоо байх бөгөөд зэрэгцэн орших хэдэн орон сууцны байшин дахь сууц өмчлөгчид нэгдэн нэг холбоо байгуулж болно. 5.3-т Холбоог зохион байгуулах хурлыг сууц өмчлөгчдийн санаачилгаар хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд тухайн нутаг дэвсгэрт байгаа орон сууц хувьчлах товчоо болон тухайн шатны Засаг даргын санаачилгаар хуралдуулна, 5.4-т Холбоог зохион байгуулах хурлын шийдвэрт хурлын тэргүүлэгчид гарын үсэг зурснаар түүнийг байгуулагдсанд тооцно гэж заасан байгаа.

-Хуулийн хэрэгжилтэд хэн хяналт тавих ёстой байдаг вэ?

-Хуульд заасны дагуу БХБЯ сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй. [ЗГМ]

ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Нийслэлийн 1524 аж ахуйн нэгж зөрчилтэй

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр аж ахуйн нэгж, иргэдийн дунд шалгалт хийжээ. Шалгалтад агаар бохирдуулах эд зүйл хэрэглэн үйл ажиллагаа явуулж буй харуулын байр, авто засвар, хувцас угаалгын газар, үйлдвэр зэрэг 1962 аж ахуйн нэгж, байгууллага хамрагджээ. Эдгээрээс 1524-т нь зөрчилтэй гэсэн мэдэгдэх хуудас, 27-д нь үйл ажиллагааг нь зогсоох албан шаардлага хүргүүлж торгожээ. Хяналт шалгалтын талаар НМХГ-ын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Н.Нарангэрэл "Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Улаанбаатар хотын зургаан дүүрэгт шалгалт хийж байна.

Уг ажлын хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэмийн зөрчлүүд илэрлээ. Тухайлбал, дугуй, хуванцар зэрэг төрөл бүрийн хог хаягдал шатааснаас болж диоксин, фуран зэрэг хортой бодис хий байдлаар ялгарч, агаарыг их хэмжээгээр бохирдуулж байна. Нийтдээ таван сая 600 мянган төгрөгийн торгууль ногдуулж, 78 обьектод цахилгаан халаагуур тавиулж, зургаан обьектын уламжлалт энгийн зуухыг бүрэн шаталтат сайжруулсан зуухаар солиулсан" гэв.

5.6 сая төгрөгийн торгууль ногдуулжээ

Хэрэв тухайн байгууллагууд албан шаардлагын дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол Агаарын тухай хуульд заасны дагуу иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-3 дахин, аж ахуйн нэгж байгууллагыг 4-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох аж. Мөн үйл ажиллагаа явуулах, газар эзэмших эрхийг цуцлах талаар холбогдох байгууллагад хүргүүлэх зэрэг шат дараалсан арга хэмжээ авна гэдгийг ч хэллээ. [ЗГМ]

ДҮҮРГҮҮД

» **БАГАНУУР**
УИХ-аас 2009 онд Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн тухай хууль баталсантай холбоотойгоор Багануур үйлдвэр технологийн паркийн эдийн засгийн нарийвчилсан үндэслэлийг ШУТИС-ийн эрдэмтдийн баг мэргэшсэн инженерүүдийн нийгэмлэгтэй хамтарч гаргаж байжээ. Гэтэл 2013 онд хийсэн эдийн засгийн нарийвчилсан үндэслэл тооцоог эргэн харах, шинэчлэх шаардлагатай гэж тус дүүргийнхэн үзэж байна. Үйлдвэрүүдийн төрөлжилт, газрын байршил, үнэлгээ тооцооллыг өнөөгийн нийгэм эдийн засгийн өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэх, газрын байршилд тохируулах талаар санал гаргажээ.

» **БАЯНГОЛ**
Хүүхдийн эмнэлэг, ахмад настны нөхөн сэргээх эмчилгээ сувиллын төв ашиглалтад ороход бэлэн болжээ. Ингэснээр 40 мянга гаруй ахмадад нас, эрүүл мэндийн онцлогт тохирсон сувилгаа үйлчилгээг үзүүлэх боломж нээгдэж буй. Найман давхар цогцолборт ахмадын эмнэлгээс гадна 150 ортой Хүүхдийн II эмнэлэг шинээр нээгдэж байгаа аж. Ингэснээр Баянгол дүүрэг дэлхийн жишигт нийцсэн эмнэлгийн тусламж үйчилгээг ахмад настнууд болон хүүхдэд үзүүлдэг болно гэж Засаг дарга нь үзэж байна.

» **НАЛАЙХ**
Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Алтангэрэл харьяалах хэлтсийн дарга нартай үр дүнгийн гэрээ байгууллаа. Цаашид төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт болон зөрчилгүй ажиллах тухай гэрээнд тусгажээ. Үүнд авлигын эсрэг хууль тогтоомжийг манлайлан хэрэгжүүлэх болон энэ оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө тусгагджээ.

» **СОНГИНОХАЙРХАН**
Нийслэлийн хэмжээнд Нарангийн энгэр, Морин болон Цагаан дабааны гэсэн гурван төвлөрсөн хогийн цэг бий. Үүний хамгийн том нь буюу 100 га талбайг эзэлдэг Нарангийн энгэрийн хогийн цэг Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хороонд байрладаг бөгөөд хог хаягдлын 60 хувь нь энд төвлөрч байна. 2009 оноос хогийн цэгийг ландфилл буюу хог хаягдлыг хөрсөөр хучин дарж, булах технологи нэвтрүүлсэн. Нийслэлийн хэмжээнд 2009 онд 308,439 тонн хог хаягдлыг авч байсан бол 2016 онд 988,390 тонн болж гурав дахин өссөн дүнтэй байна. Тиймээс хог хаягдлыг дахин боловсруулж, түлш болон бусад хэрэгтэй зүйл гарган авах шаардлагатайг албаны хүмүүс онцолж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ сонин хмх

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Цэвээндолгорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Гадаад контент, соёл энтертайнментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА
Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
Zasag.Co
"Чөлөөт хэвлэл"
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

8 658000 029112 00594

NNC NATIONAL NEWS CORP.
Bloomberg TV MONGOLIA

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

ЭФИРИЙН ОПЕРАТОР:

Ажлын байрны үндсэн зорилго: Эфирийг хуваарийн дагуу үзэгчдэд саадгүй чанартай хүргэх, эфирийн тоног төхөөрөмжийн тасралтгүй, хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, хариуцан ажиллах

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Нэвтрүүлгүүдийг хуваарийн дагуу тусгасан цаг минутад эфирт өгөх
- Дуу дүрсний пульт ажиллуулах, түүнтэй холбоотой бүх сүлжээг хариуцан эрсдэлээс урьдчилан сэргийлж, хянаж ажиллах.

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Инженерийн чиглэлээр их дээд сургууль төгссөн
- Хурдан сэтгэн бодох чадвартай, овсгоо самбаатай, техник сэтгэлгээтэй
- Телевиз болон мэдээллийн технологийн салбарт ажиллаж байсан туршлагатай, техникийн чиглэлээр засвар үйлчилгээ хийж байсан ажлын туршлагатай бол давуу тал болно.

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

- Телевизийн салбарт удаан хугацаанд тогтвортой ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Шуурхай, хариуцлагатай, цагийн менежмент сайтай, ягштал баримталдаг байх
- Бусадтай харилцах, өөрийгөө зөв илэрхийлэх ур чадвартай
- Багаар болон бие даан ажиллах, манлайлах, ажлын ачаалал даах чадвартай байх

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхний хуулбарыг нотариатаар батлуулсан байх
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Анкетыг "BLOOMBERG TV MONGOLIA" телевизийн байранд ирж бөглөх бөгөөд бүрдүүлэх материалыг хүлээлгэн өгнө үү.
Хаяг: Блю Скай тауэр, 4 давхар, № 403, Энхтайвны өргөн чөлөө 17, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14240, Монгол улс, Холбоо барих утас: 70102020

ЗГМ: Сэдэв

Салаагаар урсаж буй саарал ус

Цэвэршүүлсэн усны зах зээл эзэнгүй байна

З.Цэлмэг
@tselmegZGM

“АСЕМ-ийн дарга нар ирнэ. Та бүхэн нийслэлийн үнэрийн асуудлыг шийднэ шүү” гэж үүрэг өгсний дагуу би энэ зун Төв цэвэрлэх байгууламж дээр амралтаа өнгөрөөсөн. Ямар ч байсан үүргээ биелүүлсэн дээ” хэмээн эх орондоо саарал усны технологи нутагшуулсан доктор Д.Басандорж хүүрнэв.


Усны салбарт арвин туршлага хуримтлуулсан тэрбээр ямар ч төрлийн бохирдолтой усыг 100 хувь цэвэршүүлэх технологи гарган авчээ. Патентаа ч авсан байна. Технологио Гачуурт дахь жижиг оврын цэвэрлэх байгууламжид ашиглаж буй аж. Үр дүн нь мэдээж 100 хувь.

Эндхийн айлуудын хэрэглэсэн ус нийслэлчүүдийн цэвэр усны эх үүсвэр болсон Туул голд шууд цутгадаг. Усыг нь цэвэршүүлэх ёстой. Тиймээс Д.Басандорж доктор сургууль, цэцэрлэг, захиргаа болон орон сууцнаас гарсан бохир усыг бичил оврын цэвэрлэх байгууламжид биологийн аргаар, хоёр үе шаттай цэвэршүүлж байна. Технологийнхоо талаар дэлгэрэнгүй ярьсан тэрбээр “Энэ усыг уусан ч болно” гэв.

Дэлхийн технологийн чигийг зааж буй ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, АНУ, ХБНГУ гээд найман орны усны салбарын хамгийн шилдэг эрдэмтэдтэй хамтран ажилласны үндсэн дээр Монгол оронд тохирсон ус цэвэрлэх технологи ийнхүү нутагшиж эхэлсэн байна.

Саарал усаа дахин ашиглах талаар бид олон жил ярьж байгаа. Төрөөс усны талаар баримтлах бодлогод ч саарал усны хэрэглээг тусгаж өгсөн. Харамсалтай нь тун бүдэг бадаг. Сүүлийн үед бүр таг дуугүй болсон. Азаар энэ жил Дэлхийн усны өдөр “Ус ба хаягдал ус” нэрийн дор өрнөхөөр болсон нь мартагдах шахсан энэ сэдвийг эргэн сануулав.

Нийслэлчүүдийн усны хоногийн хэрэглээ 180 мянга гаруй шоо метр. Үүний 51.4 хувь нь дахин ашиглах боломжтой буюу саарал ус гэдгийг салбарын мэргэжилтнүүд тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, хоногт 90 мянган шоо метр усаар зам талбай, автомашинаа цэвэрлэж, ногоон байгууламжаа тэтгэж, цаашлаад өрхүүдийн дулааны асуудлыг ч шийдэх боломжтой.



The New York Times©

Идэр есийн хүйтэнд ч саарал усаа цэвэрлэх боломжтой

Даанч усны өөр нэг эх үүсвэртэй болох мөрөөдөл үнэндээ хол байна. Өнөөдөр нийслэлд саарал усыг нь дахин ашиглах боломжтой салбар бол ус ундаа, жүүсний үйлдвэрүүд. Нэг литр ундаа үйлдвэрлэж, савлахын тулд 10 литр ус зарцуулдаг. Энэ усаа 90 гаруй хувьтай цэвэршүүлдэг. Гэвч цэвэршүүлсэн усны зах зээл эзэнгүй байна. MCS-ийн ус, ундаа, шингэн уух зүйлийн үйлдвэрүүд л гэхэд цэвэршүүсэн усаа нийслэлийн ногоон байгууламж усалдаг машинд өгөхөд цаана нь өчнөөн тонноороо үлддэг аж. Үлдсэн усыг нь шугам сүлжээ татаад, зохих төлбөрийг нь төлөөд авчих хэрэглэгч байхгүй тул саарал усны эргэлтэд орсон усыг яаж шингээх аргаа олохгүй байгаа талаар Туул голын сав газрын захиргаа (ТГСГЗ)-ны дарга Я.Болдбаатар хэллээ.

Гэтэл нөгөө талд автомашин угаалгын газрууд хоногт 6-10 тонн цэвэр ус урсгаж байна. Уг нь саарал усны хамгийн том хэрэглэгч нийслэлийн хэмжээнд автомашины угаалгын газрууд байх ёстой гэдэг нь хэний ч ухаанд буухаар. Саарал усыг хэрэглээнд нэвтрүүлж чадсан улс орнуудад нэг автомашин угаахад зарцуулдаг 60-90 литр усны 70 гаруй хувь нь цэвэршүүлсэн ус байдаг аж. Гэтэл Улаанбаатар хотын 400 гаруй мянган автомашиныг нэг удаа угаахад л бидний шүдээ угаадаг цэвэр уснаас 36 мянган шоо метрийг урсгадаг гээд боддоо. Тэр ч бүү хэл цай чанадаг цэвэр усаараа жорлонгийнхоо бохирыг хөөдөг улс манайхаас өөр бараг байхгүй биз. Ингээд бодохоор бид ямар цамаан, юутай тэнэг улс вэ гэдгээ ойлгохоор.

Уг нь усаа хайрлах монголчуудын ухамсар сэргэж буй. Технологи нь ч нутагшаад эхэллээ. Д.Басандоржийн технологийг аж ахуйн нэгж байтугай өрхийн түвшинд ч нэвтрүүлэх боломжтой. Саарал усны олон технологи манайд бий. Дийлэнх нь импортынх. Тиймдээ ч нутагшиж чадаагүй нь олон. Нөгөөтэйгүүр, технологи байгаад ч хэт үнэтэй, зохистой хэрэглээг нь дэмжсэн хэм хэмжээ байхгүй бол урагшлахгүй. Авто угаалгын газарт ч ямар хэмжээнд цэвэршүүлсэн ус хэрэглэх вэ гэдгийг олон улсад стандартчилж өгсөн байдаг аж. Энэ нь цаад утгаараа хүний эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалтай холбоотой нарийн асуудал тул бүхий л талаас нь бодолцож байж хэрэглээнд нэвтрүүлэх учиртай.

Бас саарал усны эх үүсвэр төдийгүй зонхилох хэрэглэгч болсон аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн хөшүүргээр тэтгэж байж бид усны нөөцөө 2050 он хүртэл хэмнэх ёстойг салбарынхан онцолж байна. [ЗГМ]

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Я.Болдбаатар: Саарал усаа дахин ашиглах шаардлага тавьдаг

Саарал усны хэрэглээг нэвтрүүлэх нь усны нөөц багатай манай оронд маш чухал. Энэ талаар Туул голын сав газрын захиргааны дарга Я.Болдбаатараас зарим зүйлийг тодруулла.

-Саарал усны хэрэглээний стандартын талаар олон жилийн өмнөөс ярьсан. Батлагдахгүй удаж байгаа нь ямар шалтгаантай вэ?

-Ус бохирдуулагчийн төлбөрийн тухай хуулийг дагалдаж хэд хэдэн журам гарах ёстой. Тулгамдаж буй олон асуудлаас болоод энэ ажил саатаж байгаа. Үүнтэй холбоотойгоор стандарт батлагдах боломжгүй байна уу гэж харж байна.

-Танай байгууллагаас саарал усны хэрэглээг ямар байдлаар дэмждэг вэ?

-Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд ус ашиглалтын дүгнэлт гаргадаг. Зөвшөөрөл олгохдоо ашигласан усаа цэвэршүүлж, дахин ашиглах ёстой гэсэн шаардлага тавьдаг. Бетон зуурмаг, арьс шир болон ус, ундааны үйлдвэр, аялал жуулчлалын компаниудад бохир усаа цэвэршүүлдэг тоног төхөөрөмж байрлуулж, эргүүлж ашиглах шаардлага тавьдаг.

-Хэрэгжилт ямар түвшинд байна вэ?

-Харамсалтай нь, биелэлт хангалтгүй байна. Энэ нь бодлого, хяналтын тогтолцооноос гадна аж ахуйн нэгжийн санхүүгийн чадавх, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах менежмент дутаж буйтай холбоотой. Гэхдээ сайн жишээ бий. Санхүүгийн чадавхтай бетон зуурмагийн үйлдвэрүүд саарал ус хэрэглэдэг. Нэг удаа зуурмагийн торхоо цэвэрлэхэд 200-300 литр ус зарцуулдаг юм шүү дээ. Тэгээд өдөрт 4-5 удаа зуурмаг зөөдөг гэвэл ямар их ус зарцуулдгийг тооцож болно. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Д.Басандорж: Монголд тохирсон технологийг дэлхийн хаана ч хэрэглэнэ

Усны судалгааны төвийн захирал, доктор Д.Басандоржоос ус цэвэршүүлэх технологийнх нь талаар дараах зүйлсийг тодруулла.

-Хэдэн тонн ус цэвэршүүлэх чадалтай вэ?

-Хоногт 25 шоо метр ус цэвэрлэнэ. Энэ нь нэг сумын хоногийн усны хэрэглээ гэсэн үг.

-Ямар аргаар цэвэршүүлдэг юм бэ?

-Хоёр шаттай. Эхлээд хуурай бактериар цэвэршүүлнэ. Дараа нь зөвхөн усны молекулуудыг нэвтрүүлдэг, хүний арьснаас ч нимгэн биомембранаар цэвэршүүлж байна.

-Үнэхээр Монголын онцлогт тохирсон технологи гэдгийг нь яаж батлах вэ?

-Бид төгс шийдэл рүү л явж байна. Цэцэрлэг, сургуулиас гарч буй саарал ус хүйтэн. Бас монголчуудын өөх тосны хэрэглээ өндөр тул хүйтэн, тостой усыг хэрхэн цэвэршүүлэх вэ гэдэг нь хамгийн тулгамдсан асуудал. Тиймээс хүйтэн бөгөөд тостой усанд үрждэг бактери гаргаж авсан нь энэ технологийн давуу тал. Вирусийг нь хүртэл хэт ягаан туяагаар шарж, устгаж байна.

-Цэвэршүүлсэн усаа хаана хэрэглэхээр төлөвлөсөн бэ?

-Уурын зууханд хэрэглэхээр төлөвлөж байна. Манай улс усан халаалтын системтэй учраас маш их ус зарцуулдаг. Төв цэвэрлэх байгууламжаас гарсан усыг ч үүнд ашиглах юм бол их хэмжээний ус хэмнэх бололцоотой.

-Саарал усны хэрэглээнд саад болж буй олон шалтгааны нэг нь үнэ өртөг. Танай технологи хэр үнэтэй вэ?

-Манайд орж ирсэн технологийн зарим нь замбараагүй өндөр үнэтэй. Харин манай усыг өрхийн түвшинд хэрэглэнэ гэж тооцвол 1.8 сая төгрөгөөр төхөөрөмжөө авч, насан туршдаа ашиглана. Европт бол 3-4 мянган еврогоор худалдаж авдаг.

-Уур амьсгалд хэр зэрэг дасан зохицсон бол?

-Гурван есийн ид хүйтэнд ч бид усаа цэвэршүүлж л байх ёстой. Гурав, дөрвөн есийн зааг дээр тэмдэглэж авсныг үр дүнгээс нь танилцуулбал, байгууламж доторх агаарын температур тэг градус байхад миний ус 100 хувь цэвэрхэн болсон байна. [ЗГМ]

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт тавигдах нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт, мониторинг хийх ажил-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 31 радио өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт тавигдах дараах нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт, мониторинг хийх ажлыг хийж гүйцэтгэхэд оршино. Тус хороо нь Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл”-ийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 15 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт тодорхой шаардлага тавьж, хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ авч ажилладаг.

МОНИТОРИНГ ХИЙХ ЧИГЛЭЛ:

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа бүх 31 радио өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хяналт тавих зорилгоор эфирийн бичлэгийг нэгэн зэрэг, бүрэн хийж, хадгалах;
- 1 цагт дамжуулах зар сурталчилгаа нь нөхцөл шаардлага хангасан эсэх /18 мин/;
- 7 хоногийн нэвтрүүлгийн нийт цагт эзлэх дотоод бүтээлийн хувь хэмжээ нь нөхцөл шаардлага хангасан эсэх /50 хувиас доошгүй/;
- 1 хоногийн хөтөлбөрийн нийт цагт эзлэх шууд болон хөтлөгчтэй нэвтрүүлгийн эзлэх хувь хэмжээ нь нөхцөл шаардлага хангасан эсэх /15 хувиас доошгүй/;
- Хөтөлбөрийн бүтэц, түүнд гадаад болон дотоодын дууны эзлэх хувь хэмжээг тодорхойлох;
- Хөтөлбөрийн бүтэц , түүнд цаг, үе үйл явдлын мэдээ, сурвалжлагын нэвтрүүлгийн эзлэх хувь хэмжээг тодорхойлох, хөтөлбөрт эзлэх соён гэгээрүүлэх хүүхэд боловсролын танин мэдэхүйн нэвтрүүлгийн хувь хэмжээ зэрэг бусад үзүүлэлтээр мониторинг хийх.

Хяналт, мониторингийн тайлан, зөрчлийн талаарх мэдээллийг тус хорооноос гаргасан ажлын даалгаврын дагуу өдөр, долоо хоног, сар тутмаар гаргаж тогтсон хугацаанд тус хороонд ирүүлнэ.

ТАЙЛАН МЭДЭЭ ИРҮҮЛЭХ ХЭЛБЭР:

- Эфирийн өдөр бүрийн дэлгэрэнгүй протокол /06:00-00:00 цаг хүртэл/;
- Арилжааны зар сурталчилгааны цацалтын хугацааг үндсэн эфирийн цаг тус бүрээр нь тусад нь гаргасан өдөр бүрийн тайлан;
- Хөтөлбөрийг гадаад болон дотоод бүтээл гэсэн үзүүлэлтээр хувааж, үндсэн эфирийн цагт эзлэх хувь хэмжээг 7 хоногоор нэгтгэн гаргасан тайлан зэрэг бусад үзүүлэлтээр гаргасан тайлан;
- Үүссэн гомдол маргааныг шийдвэрлэх зорилгоор Захиалагчаас тусгайлан захиалсан ФМ, радиогийн хөтөлбөрийн тодорхой агуулгатай холбоотой тодорхой цагийн бичлэг.
- Захиалагчаас тухай бүр хүргүүлсэн бичлэгт тайлан гаргах гм.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлохтой холбоотой ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар туршлага, өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийн хяналт мониторинг хийх, тайлан мэдээг даалгаврын дагуу гаргах техникийн нөхцөл боломж, хяналт мониторинг хийх зөвлөх үйлчилгээний аргачлалын талаарх тайлбар, танилцуулга, дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017.03.16-2017.03.24-ний 10:00-16:00 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 03 дугаар сарын 27-ны 10.00 цагаас өмнө өөрийн биеэр ирүүлнэ.

Хаяг: **Харилцаа холбооны зохицуулах хороо**
Улаанбаатар хот 14201, Сүхбаатар дүүрэг,
Сүхбаатарын гудамж-13
Бага тойруу, 6 дугаар хороо
Метро бизнес төв, А-корпус, 5 давхар,
Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар, мэргэжилтэн Н.Тогтохсүрэн, П.Золбоо
Утас: 304257, 304258, 18001858

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-03-16

Тендер шалгаруулалтын нэр: Алхан бутлуурын ган алх нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: МС-40/2017

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Алхан бутлуур МД-70-н ган алх нийлүүлэх нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2015,2016 оны жил бүрийн борлуулалт нь тендерт санал болгож буй үниин дүнгээс багагүй байх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: тендерт санал болгож буй үниин дүнгээс багагүй байх

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан 2015 он, 2016 он

Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл ирүүлэх 2 жил

Дотоодын давуу эрх тооцно

Тендерийн хамт тендерт санал болгож буй үниин дүнгийн 2%-тай тэнцүү мөнгөн дүнгээр тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө
Утас 7018-1309 7000-1357 7017-1357
Факс 7018-1309 7000-1357

Зэвсэгт хүчний 96 жилийн ойд

Зэвсэгт хүчний хөгжлийн шинэ үе эхэлж байна



Б.Ганбаяр / ЗГМ©

Үндэсний эрх чөлөөний хувьсгалын баатарлаг эх орончдын дайчин уламжлалыг үргэлжлүүлсэн их жанжин Дамдины Сүхбаатар тэргүүтэй ардын журамт цэргийн Алтанбулаг-Шивээ Хиагтад 1921 оны гуравдугаар сарын 18-нд хийсэн түүхэн ялалтын явцад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн бий болсон билээ. Улс үндэстнээ харийн түрэмгийлэгчдээс чөлөөлж, төр улсаа сэргээн мандуулах үндэсний ардчилсан хувьсгалын эхлэлийг тавьж, өнөөгийн хөгжил дэвшлийн үндэс болсныг хойч үе нь бөхөөлгүй бадрааж, олон улсын зэвсэгт хүчний жишгэт хүргэснийг Монголын ард түмэн, зэвсэгт хүчний дайчид жил бүр тэмдэглэж ирсэн уламжлалтай.

Хүннү гүрнээс эхтэй анхны төрт улсын үеэс "Газар нутаг бол төр, улсын үндэс" хэмээх төрийг төвшитгөх алсын хараатай, онч мэргэн бодлогоор залгамжилсан Монгол төрийн бодлого олон зууны түүхийн хуудсыг өртөөлөн 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал, 1921 оны ардын хувьсгал, 1939 болон 1945 оны дайн, тулалдаан, хил хязгаараа тохинуулахын төлөөх тэмцэл, байлдааны явцад хатуужин бэхжиж, энх цагийн бүтээн байгуулалтад нэр төртэй оролцож ирлээ.

Өнгөрсөн онд Монгол Улсын зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн дүүрэн хэрэгжүүлж, ажил хөдөлмөр, амжилт бүтээл, онцлог үйл явдлаар дүүрэн түүхт ойгоо угтаж байна.

"Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичигт нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч, зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаас санаачлан боловсруулсан Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль УИХ-аар батлагдсан амжилтаар түүхийн хуудсыг баяжуулан үлдээж байна. Энэхүү багц хуулиуд батлагдсанаар улсын батлан хамгаалах тогтолцоо шинэчлэгдэн, зэвсэгт хүчний эрх зүйн орчин шинэ шатанд гарч, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага ЗХЖШ болон төрийн цэргийн байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бий болсон.

Батлан хамгаалахын багц хуулиар зэвсэгт хүчин хуурай замын болон агаарын цэргээс бүрдэн, цэргийн захиргааны удирдлагаа хэрэгжүүлдэг бие даасан байгууллага байхаар хуульчилж, "мэргэжлийн цэргэт суурилсан" байх зарчмыг тунхагласан нь төрөөс зэвсэгт хүчний хөгжлийн шинэ үеийг эхлүүлж байгаа хэрэг болно. Мөн батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллага, нийт иргэдийн оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэргэт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа мөн болохыг баталгаажууллаа. Мөн Улс орноо батлан хамгаалах үйл ажиллагааг шинэчлэх төрийн бодлогын гол зорилт болж байгаа бөгөөд үүнийг хэрэгжүүлэгч нь зөвхөн БХЯ, ЗХЖШ төдийгүй төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үүргийг нэмэгдүүлэн хуульчиллаа.

БХЯ, ЗХЖШ "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" болон батлан хамгаалах багц хуулийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, зэвсэгт хүчнийг хөгжүүлэх цогц арга хэмжээ, арга замыг тодорхойлсон "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030" баримт бичгийг төрийн цэргийн байгууллагуудтай хамтран боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Засгийн газарт өргөн барьсан.

Түүнчлэн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээг улс орны хэмжээнд төлөвлөн зохион байгуулах, бусад төрийн захиргааны төв байгууллагуудтай энэ үйл ажиллагааг уялдуулах, орон нутгийн удирдлагуудтай батлан хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах, зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг шинэчлэхэд анхаарч ажиллах, "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030" баримт бичгийн хэрэгжилтийг хангах үүднээс "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2016-2020 онд хөгжүүлэх хөтөлбөр"-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн албажуулж, зэвсэгт хүчний хөгжлийн шинэ гараг эхлүүллээ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УИХ-ын 2016 оны намрын чуулганаар батлагдсан батлан хамгаалахын багц хууль нь төрийн цэргийн байгуулал нэгдмэл байх, улс орны батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүссэн олон шинэ харилцааг үр дүнтэй зохицуулах бололцоог олгох, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг сайжруулах, зэвсэгт хүчний хөгжлийн бодлогыг тодорхойлох, стратегийн ба нэгдсэн ажиллагааны төлөвлөлтийг төгөлдөржүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн баримт бичиг болсон.

Дэлхийн тавцанд Монгол Улсын нэр хүндийг өндөрт өргөсөн түүхэн арга хэмжээний нэг болох Ази-Европын 11 дэх удаагийн дээд түвшний уулзалтын үеийн хамгаалалтад зэвсэгт хүчний 2400 орчим алба хаагч, 100 гаруй нэгж техниктэйгээр 12 чиглэлээр мэргэжлийн өндөр түвшинд үүрэг гүйцэтгэж, чуулга уулзалтад хүрэлцэн ирсэн гадаад орны зочид, төлөөлөгчдийн аюулгүй байдлыг ханган, урлаг, соёл, төрийн ёслолын арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулсан.

Таван тивийн 46 орны 2000 гаруй цэргийн алба хаагч анх удаа нэг дээвэр дор цугларан "Хааны эрэлд-2016" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт, дадлагыг Монгол Улсад зохион байгуулснаараа онцлог байлаа.

Түүнчлэн "Аминд үл хүрэх зэвсэг-2016" олон улсын сургалт, Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудын цэргийн холбоочдын сургууль, НҮБ-ын цэргийн ажиглагч болон штабын офицерын дамжаа болон ОХУ-тай хамтарсан "Сэлэнгэ-2016", АНУ-тай хамтарсан "Бүс нутгийн хамтын ажиллагаа", "Баланс-мэжик", "Алтан тал", "Энхийн өвөл-17", БНЭУ-тай хамтарсан "Нүүдэлчин заан", БНТУ-тай хамтарсан "Нүүдэлчин дайчид", Катар улстай хамтарсан "Шийдэмгий шийдвэр", Японы улстай хамтарсан "Зам-2016" сургууль, сургалт, дадлагуудыг тус тус зохион байгуулсан нь Монгол Улсын зэвсэгт хүчин болон олон улсын цэргийн алба хаагчдын хамтын ажиллагааг дээшлүүлэх, итгэлцлийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулаа.

ОХУ-д зохион байгуулагдсан "Спасская башня", БНСУ-д явагдсан "Олон улсын цэргийн хөгжимчдийн болон хүндэт харуулын наадам", ОХУ, Казахстан улсад болсон "Танкийн биатлон", "Мэргэн буудагчийн зааг", "Хээрийн гал тогоо" тэмцээн, "Рио-2016" олимпийн их наадам, Швейцарийн холбооны улсад зохион байгуулагдсан жүдо бөхийн цэргийн ДАШТ, Катарт болсон буудлагын ДАШТ зэрэг томоохон арга хэмжээнүүдэд амжилттай оролцсон нь зэвсэгт хүчний алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, талуудын хооронд хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй байлаа.

Монгол, Австри улсын Засгийн газар хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд цэргийн төв эмнэлэгт Австрид бүртгэлтэй "AME International" компаниас 60 нэр төрлийн 123 нэгж багаж, тоног төхөөрөмжийг хүлээн авч, өмнө нь хийх боломжгүй байсан 17 нэр төрлийн шинжилгээ, зургаан төрлийн мэс засал хийх боломжийг бүрдүүлж, 2016 онд нийт 84680 гаруй хүнд эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн статистик гарч, "Эрүүл монгол хүн" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулаа.

Дөрвөн жил тутам уламжлал болгон зохион байгуулагддаг МБАТ-ий XIV их наадамд "Алдар" спорт хорооны баг, тамирчид спортын 18 төрлөөр оролцож, нийт 83 алт, 52 мөнгө, 30 хүрэл медаль хүртэн нэгдсэн дүнгээр өвлийн болон зуны төрлүүдэд өмнөх спортын их наадмуудад үзүүлсэн амжилтаа бататган 12 дахь удаагаа тэргүүлсэн нь түүхэнд дахин давтагдашгүй өндөр амжилт боллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч, зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Оюутан цэрэг" хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 1000 орчим, тус хөтөлбөр хэрэгжсэн гурван жилийн хугацаанд нийт 2400 гаруй оюутан залуус хамрагдаад байна.

Улсын онцгой комиссын шийдвэрээр зэвсэгт хүчний томилогдсон бүрэлдэхүүн Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн голд 45 метрийн урттай 40 тонны даацтай хөвөгч гүүр тавих ажлыг амжилттай зохион байгуулж, нийт 346,828 зорчигч, 58,100 тээврийн хэрэгсэл, 39,039 толгой мал нэвтрүүлж, гамшгийн үед аврах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүллээ.

БХЯ, ХНХЯ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зэвсэгт хүчний 15 анги, байгууллагын 286 цэргийн алба хаагч, ҮБХИС-ийн Ахлагчийн сургууль болон Ахлагч бэлтгэх төвийн 260 цэргийн алба хаагчдад хүнд машин механизмын оператор, засварчны хос мэргэжил эзэмшүүлсэн.

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОО

Энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэг, оролцоо тасралтгүй нэмэгдэж, Монголын цэргийн ажиглагчид, цэргийн багууд, цэргийн эмч, сувилагч нар дэлхий дахинаа энх амгалан байдлыг сахиулах, шинэ тулгар тусгаар улсын ард түмний нийтлэг эрх ашгийг хамгаалах, тусгаар тогтнол, ардчиллыг бэхжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж ирснээр зэвсэгт хүчний нэр хүнд дээшилж, манай улсын дэлхийн тавцанд эзлэх байр суурь баталгаажиж байна.

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд зэвсэг хүчний алба хаагчид БНАКУ, Баруун Сахар, Судан, Этиоп, Эритриа, Гүрж, Чад, БНӨСУ, Афганистан улс болон Суданы Дарфур муж, хилийн маргаантай бүс нутаг болох Абией мужид явагдсан НҮБ-ын 11 энхийг сахиулах ажиллагаа, Ирак, Косово, Афганистан улсад явагдсан энхийг дэмжих гурван ажиллагаа, нийт 14 ажиллагаанд давхардсан тоогоор нийт 14000 гаруй цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэлээ.

Өнөөдрийн байдлаар БНАКУ, БНӨСУ, Судан, Баруун Сахар, Абией, Афганистан улсад явагдаж буй энхийг дэмжих зургаан ажиллагаанд 1100 гаруй цэргийн алба хаагч, цэргийн ажиглагч, зөвлөх, холбогч, штабын офицерууд үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчний эзлэх байр суурь жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 2014-2016 онд Өмнөд Судан улс дахь "UNMISS" ажиллагаанд бүсийн командлагчаар бригадын генерал Д.Баярсайхан, хурандаа С.Амарсайхан нар үүрэг гүйцэтгэж, ажиллагааны хойд бүсэд НҮБ-д цэрэг хандивлагч 5-6 орны 6-7 мянга гаруй цэргийн алба хаагчдыг удирдан зохион байгуулж, НҮБ-ын дээд штаб, нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч болон Хүчний командлагчаас "Онц" үнэлгээтэйгээр үүргээ гүйцэтгэсэн.

Монгол Улсын зэвсэгт хүчин дэлхийн улс орнуудын энх тайван, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт тууштай оролцож, НҮБ-ын байнгын цэргийн хүчний тогтолцоонд чухал байр суурийг эзлэн, НҮБ-д цэрэг хандивлагч орнуудын дунд 2017 үзүүлэлтээрээ 30 дугаарт жагсаж байгаа нь төрийн энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, улс орноо батлан хамгаалах боломж, чадавхийг нэмэгдүүлэн ажиллаж байгаагийн илэрхийлэл юм.

Зэвсэгт хүчний жанжин штаб

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017-03-16

Тендер шалгаруулалтын нэр: Төрөл бүрийн шиберэн хаалт нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МС- 33/2017

"ДЦС-4" ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос : Төрөл бүрийн шиберэн хаалт нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын дундаж тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Аудитаар баталгаажуулсан 2015, 2016 оны санхүүгийн тайлан ирүүлэх

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /2015,2016 оны ирүүлэх

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны..04 дугаар сарын 17-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны .04. дугаар сарын 17.-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо "ДЦС-4 ТӨХК-ийн байр 3 давхар 312, 313 тоот өрөө
Утас: 70181309, Факс: 70181309

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017-03-16

Тендер шалгаруулалтын нэр: Хөргөгч цамхагийн /градерны/ тоноглол нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МС- 30/2017-01

"ДЦС-4" ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос: Хөргөгч цамхагийн /градерны/ тоноглол нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь Хаан банк 5038008126 дансанд 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын дундаж тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Аудитаар баталгаажуулсан 2015, 2016 оны санхүүгийн тайлан ирүүлэх

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /2015,2016 оны ирүүлэх

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо "ДЦС-4 ТӨХК-ийн байр 3 давхар 312, 313 тоот өрөө
Утас: 70001357, 70181309 Факс: 70181309

Амьдралын хэв маяг

ЭРҮҮЛ АМЬДРАЛ



Харин одоо 30, 40, тэр ч бүү хэл 50 нас гарсан хүмүүс амьдралын хэв маяг, өөрийгөө үнэлэх үнэлэмжээ дахин нэг боломж өөртөө олгож эхэллээ.

Эрүүл амьдрах 1000 боломж

25 нас хүрэхээсээ өмнө турахгүй бол цаашид хэзээ ч турахгүй гэсэн ойлголт их байв

Г.Сайнзаяа
@sainzayaZGM

Сүүлийн жилүүдэд монголчууд эрүүл мэнддээ ихээхэн анхаарах болсон. Энэ сайшаалтай хэрэг. Гэвч үүнээс ч сайшаалтай нэг хэрэг нь эм тангаар "угжих" биш хөдөлгөөнөөр, байгалийн аргаар эрүүлжихийг эрмэлзэж байна. Зарим байгууллага фитнесс төвүүдтэй бартер хийж, ажилчдынхаа эрүүл мэндэд анхаардаг. Энэ нь ерөнхийдөө идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх нь ажлын бүтээмжийг сайжруулдагтай холбоотой байх. Гэхдээ л хэн хэндээ хожоотой л зүйл шүү дээ.

Үнэгүй фитнесс олдохгүй байсан ч хувцас, гангарааны мөнгөө фитнесс төвүүдэд зарцуулдаг хүмүүс ч олширчээ. "Хувцас бурхан, бие чөтгөр" гэдэг үг бол хөдөлгөөнөөр идэвхтэй хичээллэгсдийн хувьд бол "Хувцас чөтгөр, бие бурхан" юм байна. Хуучин 25 нас хүрэхээсээ өмнө турахгүй бол цаашид хэзээ ч турахгүй гэсэн ойлголт манайд их байв. Харин одоо 30, 40, тэр ч бүү хэл 50 нас гарсан хүмүүс амьдралын хэв маяг, өөрийгөө үнэлэх үнэлэмжээ өөрчлөхөөр дахин нэг боломж өөртөө олгож эхэллээ. Тэдний гаргасан үр дүн ч гайхалтай.

Монголын алдартай фитнесс мисс, Азийн аварга Г.Гансаруул "Хоёр дахь хүүхдээ төрүүлсний дараа өөрийгөө толинд хараад, ерөөсөө л турах хэрэгтэй гэж эрс шийдсэн. Бас нэг танил маань намайг "Тогоо, шанага хангинуулахаас өөр юм мэдэхгүй бүдүүн хар авгай" гэж доромжилсонд голдоо ортол гомдож билээ. Тэгэхээр нь би шаралхаж, "Намайг ямар болохыг хараарай" гэж бодоод хоёр хүүхдээ дагуулаад фитнесст явдаг байлаа" хэмээн фэйсбүүк хуудастаа бичжээ. Тэрбээр өөртөө хатуу зорилт тавьж, өөрийгөө ялан дийлж 56 кг турж, одоогийн үр дүнд хүрсэн. Г.Гансаруул одоо өөртөө итгэлтэй, аз жаргалтай, хэний ч өөдөөс инээмсэглэх сэтгэлийн тэнхээтэй гайхалтай бүсгүй. Хүсэл байгаад хичээж чадвал боломж хэн бүхэнд байдгийг түүнээс харж болно. Энэ мэт илүүдэл жин, элдэв өвчнөөсөө салж, гайхалтай өөрчлөлт хийж чадсан хүмүүс олон болжээ.

Хоёр, гуравхан жилийн өмнөхтэй харьцуулахад үйлчилгээний зориулалттай барилга бүхэн дасгал хөдөлгөөн, эрүүл амьдралыг дэмжих төвтэй болсон. Төрөл нь ч хүртэл сонголттой. Фитнесс, кросс фит, баллет, халуун йог, анти-гравити буюу агаарын йога, бүжигийн бүх төрөл, спиннинг гээд л өөрийн хүсэл сонирхол, хүчин чадал, сэтгэл зүйдээ тохирсон төрлөөр хичээллэх боломж бий. Үсэрч, цовхчихгүй тайван аргаар турахыг хүсэж байгаа хүмүүс балет, йог сонгох нь зүйтэй.

"Хувцас чөтгөр, бие бурхан" гэдэг үзэл дэлгэрчээ

Харин нэг сумаар хоёр туулай буудахыг эрмэлзэгчид салса, бачата, гудамжны гээд аль ч төрлийн бүжгийн төвд элсэж болно. Илүүдэл жингээ ч хасна, бүжиглэх хэрэг гарвал олны нүдийг ч хужирлана.

Харин эрч хүч мэдэрч, зогсолтгүй хэмнэлээр давшилдаг хүмүүст спиннинг, кросс фит тэргүүтэн зохимжтой. Харин бие дааж, өөрөө дасгалаа тааруулмаар байвал фитнесс төвд хандаарай. Эдгээр төв ч халуун сэтгэлээ харамгүй хайрлаж, жилийн дөрвөн улиралд элдэв хямдрал зарладаг. Цагийн хуваарь нь уян хатан, 2-10 хүртэл салбартай. Үүр цайхтай уралдаж, өглөөний хүн болох. Шөнийн идэвхтэн бол 24.00 цаг хүртэл ч үүд хаалга нь нээлттэй. Ийм олон боломж олгож байгаа нь биднийг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэж, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгож чадахгүй байгаа бол буруу өөрсдөөсөө хайхаас өөр замгүй болгох шиг.

Дасгал хөдөлгөөний төвүүд амралтын өдрүүдэд дугуйтай аялж, ууланд авирдаг. Мөн бооцоотой тэмцээнүүд зохион байгуулдаг. Хэн өөрийгөө дийлж, өөрчлөгдөж чадсан нь нэг сая төгрөг, бүр автомашин ч хожих боломжтой.

Дасгал хөдөлгөөнөөр идэвхтэй амьдардаг хүмүүсийн гаргасан нэгэн уриалга олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн анхааралд өртсөн нь саяхан. Энэ нь нийгмийн даатгалын мөнгөөр спорт төвүүдэд үнэгүй хичээллэх эрхтэй болох юм. Тэгвээс хэдэн мянган төрлийн өвчний эх үүсвэр болсон хөдөлгөөний дутагдлаас зайлсхийхэд том алхам болж чадах билээ. [ЗГМ]

ШИНЭ ЖОР

Эрүүл, тэжээллэг фит хоол

Фитнесс, аэробик, бүжиг, иог зэрэг идэвхтэй дасгал хөдөлгөөн хийж, турж галбиржих гэж байгаа бол эдгээрийн хажуугаар зөв хооллох нь маш чухал үр дүн авчирдаг. Эрүүл, зөв хооллолт буюу фит хоол нь 20 төрлийн амин хүчлийн найрлага бүхий өвөрмөц шинж чанартай уургийг агуулдаг. Мөн өдөрт таван удаа, 3-5 цагийн зайтай, бага хэмжээгээр хооллох ёстой. Ингэснээр цусан дахь сахарыг тогтмол хэмжээнд барихаас гадна бодисын солилцоог идэвхжүүлж, биен дэх өөхийг эрчимтэй шатаадаг ажээ.

Ингээд тэжээллэг, фитнесс хоолыг санал болгож байна. Фитнесс хоол нь хүний биеийн өөх тосыг задалж, булчинд тэжээл болж, эд эсийг сэргээж, хоол боловсруулах тогтолцоог сайжруулахаас гадна уургийн дутагдлаас сэргийлэх амин дэмээр баялаг юм. Тиймээс энэхүү хоолыг хийхдээ давс, хоол амтлагч хэрэглэж оливийн тосноос бусад тосонд шарж, хуурч болохгүй.

ЖИГНЭСЭН НОГОО, ХАЙРСАН ЗАГАС



ОРЦ:
Загасны мах
Лууван
Брокколи
Цэцэгт байцаа
Ногоон сонгино

ХИЙХ АРГА: Загасны махыг хоёр талаас нь амтлан оливын тосонд хийж, болтол нь хоёр талаас нь хайрна. Загасны мах амархан болдог тул хэт их хайрч, шарж болохгүй. Лууванг чанаж эсвэл түүхийгээр нь хэрэглэх бөгөөд цэцэгт байцааг 15 минут жигнүүр дээр жигнэж болгоод, лууван болон загасны махтай хольж амталж иднэ.

ЗӨВ ХЭВШИЛ

Байгальд ээлтэй хүн гэж хэн бэ



Та өглөө ажилдаа очоод тамхиа асаагуураар асааж татчихаад, өдрийн хоолоо хуванцар аяганд хийж аваад, хоолоо шингээх гэж нэг лааз хийжүүлсэн ундаа авч уулаа гэж төсөөлье. Та дөнгөж сая 1112 жил байгальд шингэхгүй хог хаягдал гаргалаа. Итгэмээргүй байгаа биз. Техник технологи хөгжиж, ган төмөр, цэвэр модон эдлэл бидний хэрэглээнээс халагдсан. Оронд нь байгальд шингэх гэж хэдэн зуун дамнадаг хуванцар ноёлж байна. Фэйсбүүкээр нэгэн хэсэг "Би байгальд хог хаядаггүй" уриалгын доор хүмүүс нэгдэж, зургаа авахуулаад л, байгууллагууд хог цэвэрлэж сүржин явдал болов. Гэтэл богинохон зунд тохиох цөөхөн амралтын өдрүүдэд байгальд гарахдаа хог хаяхгүй байлаа гээд бид байгальд ээлтэй иргэн болчихгүй. Урьдаар өөрийнхөө үйлдвэрлэдэг хог хаягдлыг эхлээд анзаарч, түүний хор хохирлын талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. Монголчууд бид шинэ жил, цагаан сар, наадам дөхөхөөр гэр орноо цэвэрлэж, хэрэггүй зүйлсээ хаядаг бичигдээгүй заншилтай. Гэхдээ бүх юмаа нэг уутанд хийгээд хог дээр гаргачихсан байхтай олон таардаг. Угтаа бол бидний үйлдвэрлэж, байгаль эхийг хэдэн мянган жилээр дарлаж байгаа хог хаягдлыг багасгах олон арга бий. Өмсөхгүй хувцас, хэрэглэхгүй эд зүйлсээ солилцдог бартер өдөрлөгүүд, хандивын аян, гаражийн худалдаа гээд арга саам олон. Түүнчлэн бидний өдөр тутамд хэрэглэж заншсан хуванцар хэрэглэл, гялгар уутыг орлох бүтээгдэхүүн олширчээ. Дэлгүүр явахдаа, хүнс цуглуулахдаа сүлжмэл торон уут, даавуун уут халааслаад гарч болно. Эсвэл зоогийн газраас хоол авч явахдаа өөрийнхөө савыг аваад гарах, байнга нэг газраас захидаг бол хоёр ээлжийн сав өгч явуулахад ч нээлттэй.

Үр хүүхдээ эрүүл орчинд, шавхагдаагүй нөөцтэй, ундны цэвэр устай үлдээх алхам биднээс эхлэх хэрэгтэй гэж байгаль хамгаалагчид сануулж байна. Бид багахан санаачилга гаргаж, зорилт дэвшүүлэхэд л байгальд шингэдэггүй хуванцар, гялгар уутнаас татгалзах бүрэн боломжтой. [ЗГМ]

ЭД ЗҮЙЛСИЙН БАЙГАЛЬД ШИНГЭХ ХУГАЦАА

Шил	4000 жил	Лааз	10 жил
Хуванцар аяга	1000 жил	Хөнгөн цагаан сав	100 жил
Хуванцар карт	1000 жил	Асаагуур	100 жил
Нэг удаагийн аяга таваг	500 жил	Тамхины иш	2 жил
Хуванцар сав	400 жил	Цаас	гурван сар

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

REGIONAL UPGRADES OF SANITARY AND PHYTOSANITARY MEASURES FOR TRADE PROJECT

ADB

VACANCY ANNOUNCEMENT

The Government of Mongolia with support from the Asian Development Bank (ADB) has developed the "Regional Upgrades of Sanitary and Phytosanitary Measures for Trade". The project objective is to improve the sanitary and phytosanitary control, testing, and inspection systems. The Executing agency is the Office of the Deputy Prime Minister and Implementing agencies are the General Agency for Specialized Inspection and the Veterinary and Animal Breeding Agency. Under the project, the Office of the Deputy Prime Minister is seeking to recruit a qualified **Procurement Specialist** ("Consultant").

Objective of the assignment is to oversee and ensure timely implementation of all procurement activities. He/she will ensure adherence to Asian Development Bank and Government of Mongolia's applicable procurement procedures and guidelines.

Tasks and responsibilities:

- Preparing and/or reviewing bid documents including terms of reference, bills of quantities and cost estimates
- Developing technical specification of works, goods and services
- Preparing and/or updating procurement plans and an integrated implementation arrangement for all the BCPs, laboratories, capacity development, training, and IMS components
- Coordinating and scheduling procurement activities
- Preparing progress report on procurement activities and focal for all relevant documents
- Requesting for and reviewing proposals
- Assisting in bid evaluations and advising on procurement procedures
- Overall management of the procurement of the works, goods and services to ensure transparency, and compliance of the Asian Development Bank Guidelines and Government of Mongolia procurement policies and procedures
- Providing advice and recommend measures to executing and implementing agencies to adopt best practices in good governance particularly for public procurement and project administration

Qualifications and Experience:

- Academic/professional qualification in purchasing, business, engineering or relevant field. A master degree is preferable.
- A minimum of 10 years professional experience and with related experience of 5 years in design and construction of infrastructure (buildings, roads etc.).
- Work experience in at least one border crossing point and/or one ICT project, and worked at least on two ADB/other development agencies funded projects is desirable.
- Proficient in English language.

CONTRACT DURATION AND CONDITIONS: The assignment is expected to start in April 2017. The Consultant will be selected in accordance with the relevant regulations of the Government of Mongolia and the Asian Development Bank.

Qualified candidates should submit a cover letter indicating why she/he considers her/himself suitable for the position, detailed CV highlighting skills/experience, copy of diplomas or certificates and two reference letters from last two employers no later than **12:00 PM, 24 March 2017. Only those successful candidates will be contacted.** The application documents shall be submitted in person to the below address. The submitted documents will not be returned to the applicants. Incomplete applications would not be considered. If you need any further details, please feel free to contact us.

Contact address: Room 480, Government House, Ulaanbaatar, Mongolia. Tel: +(976) 51 264077, 260382

Лавлах

ЭРҮҮЛ МЭНД

Менингитийн вакцин хийж байна



Б.Ганаа
ЗГМ

Менингококкт халдвараар 0-5 хүртэлх насны хүүхдүүд өвчилж, хүндрэх хандлагатай байна. Тиймээс нийслэлийн Эрүүл мэндийн газраас урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргажээ.

Мөн энэхүү өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ХӨСҮТ-өөс вакцинжуулж эхэллээ. Эцэг, эхчүүдэд хандаж хэлэхэд лхагва, баасан гарагт 9.00-14.00 цагт менингитээс сэргийлэх вакцинийг хийж байгаа аж. Зургаан сараас дээш настай хүүхдүүд менингококкийн вакцинд хамрагдах боломжтой. Вакцин хийлгэхэд 13500 төгрөг төлөх юм байна. Уг өвчний шинж тэмдэг нь арьсан дээр цусархаг тууралт гарах, тархины зөөлөн бүрхүүл, тархины эдийн үрэвслээр илэрдэг бөгөөд Neisseria meningitidis гэгдэх нянгаар үүсгэгддэг амьсгалын замын цочмог халдварт өвчин юм. Түүнчлэн агаар дуслын замаар халдварладаг тул цэцэрлэгийнхнийг урьдчилан сэргийлэхийг ХӨСҮТ-ийн эмч нар зөвлөлөө. [ЗГМ]

БОЛОВСРОЛ

Туркийн тэтгэлэгт хамрагдах боломжтой

Г.Оюунтөгс
ЗГМ

Бүгд найрамдах Турк улсын Засгийн газрын бакалаврын тэтгэлэгт хөтөлбөрийн бүртгэл эхэллээ. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахыг хүсвэл www.turkiyeburslari.gov.tr цахим хаягаар бүртгүүлэх боломжтой. Шуудан болон өөрийн биеэр авчирсан бүртгэлийн материалыг хүлээн авахгүй аж.

Тэтгэлэгт 1996 оны нэгдүгээр сарын 1-нээс хойш төрсөн бөгөөд дунд сургуулиа төгссөн, эсвэл энэ жилийн төгсөх ангийн сурагчид хамрагдах эрхтэй юм байна.

Мөн англи хэлний түвшин тогтоох шалгалтын оноогүй иргэдийг бүртгэх боломжгүй бөгөөд өмнө нь бакалаврын тэтгэлэгт хамрагдаагүй байх шаардлага тавьжээ. Тэтгэлгийн бүртгэл энэ сарыг дуустал үргэлжилнэ. [ЗГМ]

ХЭРЭГ ЗӨРЧИЛ

Шалгалтаар 50 жолооч согтуу байжээ

Замын цагдаагийн алба өнгөрсөн мягмар гарагт нийт 273 дуудлага хүлээн авчээ. Үүнд ослын 203 дуудлага бүртгэсэн бөгөөд зургаан хүн хүнд, хөнгөн байдлаар гэмтжээ. Үүнээс явган зорчиж байсан хоёр хүүхэд өртсөн байна. Цагдаагийн байгууллагын хяналт шалгалтаар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 50 жолооч ийг илрүүлжээ. Урин дулааны улиралд иргэд мотоцикль, мопед, унадаг дугуйтай замын хөдөлгөөнд оролцох, бага насны хүүхдүүд сургуулийн болон гэр орчмын гадна талбайд тоглож байгаад зам тээврийн осолд өртдөг тул болгоомжтой байхыг Замын цагдаагийн албанаас анхааруулаа. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	**09.10** “Цэрэг эрс” Оросын уран сайхны кино тавдугаар анги	**08.00** "Bloomberg Daybreak Asia"	**09.00** "Cook Club" хоолны шоу нэвтрүүлэг	**09.30** “Тог, тог, тог” хүүхдийн нэвтрүүлэг
12.00	**11.20** Энд гарц байна. “Хөрсний бохирдол”	**11.30** "Алсын хараа" нэвтрүүлэг	**11.15** "Тамирын багш" ОАК	**12.00** “Хөтөч” мэдээллийн хөтөлбөр
14.00	**14.00** “Нандин” ток шоу	**14.30** "Технологийн шийдэл" нэвтрүүлэг	**14.10** "80 саяын уналт" шоу нэвтрүүлэг	**13.00** “Наашаа цаашаа” нэвтрүүлэг
18.00	**17.00** “Энх мэндийн хадаг” концерт СТА Э.Чулуунчимэг	**17:00** "Bloomberg Surveillance"	**17.00** "Агуу бүтээн байгуулалт" баримтат кино	**15.00** “Өөрчлөлт” нэвтрүүлэг 97 дахь хэсэг
20.00	**20.00** “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр	**20.30** "Шилдэг санаа" нэвтрүүлэг	**18.35** "Дэлхийн атлас" танин мэдэхүйн нэвтрүүлэг	**20.00** “Оргил цаг” мэдээллийн хөтөлбөр
22.00	**21.05** “Соёл-Эрдэнэ” хөтөлбөр	**22.00** "Эзэнт гүрнийг босгосон нь" нэвтрүүлэг	**20.40** "Монголчууд нийгэм журамд давшин орсон нь" цуврал	**21.00** "Оёдлын газрын боловсон эрчүүд" СОАК

ОНЦЛОХ ҮЗВЭР

“Кихот ноён”



"Кихот ноён" жүжгийг анх 1743 онд Францын Дуурь, бүжгийн театрт тавьж байжээ. Харин 1971 онд Монголын ДБЭТ-т хөдөлмөрийн баатар, ардын жүжигчин Б.Жамъяндагвын найруулгаар бүжгэн жүжиг болгон тоглосон түүхтэй. 2008 онд орчуулагч Н.Пүрэвдавга орчуулснаар Монголд анх удаа УДЭТ-т драмын жүжиг хэлбэрээр тавьсан байна. Жүжгийн гол дүр хэрмэл хүлэг баатар Дон Кихот, түүний зарц Санчо Панса хоёрын дүрд УДЭТ-ын уран бүтээлч, гавьяат жүжигчин Б.Жаргалсайхан, жүжигчин Г.Амгаланбаатар нар тоглох юм. Тус жүжгийг энэ сарын 16-29 хүртэл орой бүр 19.00 цагаас УДЭТ-ынхан үзэгчдийн хүртээл болгож байна. [ЗГМ]

ҮЗВЭР

УДЭТ

Б.Цогнэмэхийн “Тэнгэрийн хүү” жүжгийн энэ сарын 25-нд 18.00 цагт тоглоно.

CORPORATE CONVENTION HALL

“Big show” хэмээх stand up comedy тоглолт энэ сарын 31-нд 19.00 цагт болно.

УЛААНБААТАР ЧУУЛГА

“5 Tones” үндэсний болон цахилгаан хөгжмийн зэмсгийг хослуулсан дан хөгжмийн тоглолтыг энэ сарын 18-нд толилуулахаар боллоо.

УДБЭТ

А.Хачатуряны "Спартак" бүжгэн жүжгийг энэ сарын 19-нд 17.00 цагт тоглох гэж байна.
Ж.Мэнд-Амарын "Үйлийн гурван толгой" балетийг тайзнаа амилуулсны 30 жилийн ойн хүндэтгэлийн тоглолт энэ сарын 28-нд болно. УДБЭТ-ын үе үеийн шилдэг уран бүтээлчид тоглосон уг бүтээлийг энэ жил 133 дахь удаагаа тоглох гэж байна.

Агуу хөгжмийн зохиолч А.Моцартын "Дон Жуан" дуурийг ирэх сарын 1-нд 17.00 цагт толилуулна.

UB PALACE

“Хайр дүүрэн” бүх оддын нэгдсэн тоглолт энэ сарын 17-нд 19.00 цагт болох гэж байна.

CROCUS EVENT HALL

Цэргийн баярт зориулсан рок, попын дуучдын нэгдсэн тоглолт энэ сарын 17-нд 19.00 болно.


ONE EVENT HALL

Наурызын баярт зориулсан удэшлэг энэ сарын 19-нд 18.00 цагт болно. Тасалбарын үнэ 75 мянган төгрөг.

IMAX

Найруулагч Б.Эрхэмбүрэнгийн “Манан зүсэг” кино маргааш нээлтээ хийх гэж байна.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
1. Шинэ аварга Ч. Санжаадамбын төрөлх сум
2. Дэлхийн дээвэр, хамгийн өндөр цэг
3. Монголчуудын байлдан дагуултад хамгийн гол үүрэг гүйцэтгэгсэд
4. Хорвоо ертөнц
5. Нэгэн арилжааны банк
7. Мал амьтны гарвал, удам
10. Өвөрмөц шинж чанар
11. Дархан мужааны гол хоёр багаж
12. Найз нөхөд
14. Өсвөр залуу
15. Хил нэвтрэх эрх

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Манжтай дайчин тэмцсэн халхын баатар Цогтын цол хэргэм
3. Бодончорын эх, домогт хатан
5. Үзэсгэлэнт сайхан
6. Эсрэг дүрийн мастер агсан, МУГЖ
8. Хосоороо явдаг гоёмсог шувуу
9. Хоол амтлагч
11. Үндэсний үйлдвэрийн шоколад
13. Удирдагчдын мэдэгдэл, тушаал заавар
16. Алунгоо хатнын хань нөхөр
17. Нэгэн төрлийн загас
18. Дэлхийн II дайны үеэр алагдах гэж байсан олон мянган еврей хоригдлыг аварсан герман эрдэмтэн

Өмнөх дугаарын хариу / 03.15

			Б				П				
		Л	А	М	А	■	О	Л	О	М	
О	Д	■	Я	■	Н	Ү	Д	■	Л	■	Я	Н
	У	Х	Н	А	■	Н	■	Б	О	О	М	
	У	■	■	Ц	Э	Э	Н	Э	■	■	А	
А	Т	■	Т	А	■	Э	■	Э	Х	■	А	Д
		Б	У	Г	А	■	О	Р	О	Г		
			Н						Л			

ЗГМ: СУДОКУ

5								
		7	2			5		
		8				9		
				9				4
7	4			3	1			2
1	3				2			
			5			8	2	
		5					3	
	2			4			6	


4	6	5	3	2	7	8	1	9
9	2	1	8	5	4	7	3	6
3	8	7	9	1	6	2	4	5
7	1	9	2	8	5	4	6	3
8	3	4	1	6	9	5	7	2
6	5	2	4	7	3	1	9	8
5	4	8	6	9	1	3	2	7
2	9	3	7	4	8	6	5	1
1	7	6	5	3	2	9	8	4

(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

III.15	III.16	III.17	III.18	III.19
5° / -7° | 6м/с / 5м/с	2° / -10° | 7 м/с / 6 м/с	3° / -10° | 8 м/с / 6 м/с	4° / -8° | 7 м/с / 5 м/с	4° / -6° | 8 м/с / 5 м/с
Үүлшинэ	Үүлшинэ	Үүлшинэ	Үүлшинэ	Бага зэргийн цас орно



ЗУРХАЙ



Билгийн тооллын 19
Хаврын тэргүүн хар бар сарын найман цагаан мэнгэтэй хар бар өдөр.
Ус засуулбал: Сайн нөхөртэй нөхөрлөнө
Наран ургах, шингэх: 07.05-18.54
Барилдлага: Хотол чуулган
Шүтэн барилдлага: Төрөхүй
Суудал: Мод

Аргын тооллын гуравдугаар сарын 16. Бархасвадь гараг. Билгийн тооллын 19. Салхины эх одтой, хар бар өдөр.

Өдрийн наран 07.05 цагт мандан, 18.54 цагт жаргана. Тухайн өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, сан тавиулах, угаал үйлдэх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгад болон цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нөхөртэй учирна" гэж зурхайд тэмдэглэжээ.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

Бээжин-Москва	07.45	14.28
Москва-УБ	21.35	07.30
УБ-Эрээн	20.00	10.25
УБ-Бээжин	07.15	14.04
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	07.30	09.45
Бээжин-УБ	10.50	13.20
УБ-Сөүл	07.45	12.05
Сөүл-УБ	13.20	16.05
УБ-Хонгконг	07.55	12.55
Хонгконг-УБ	13.25	18.05
УБ-Ханбумбат	08.40	09.50
Ханбумбат-УБ	10.40	11.45

[ЗГМ]

“ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ” СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

“ZGM-FINANCIAL TIMES-NYT” ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ, СУРВАЛЖЛАГАТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗГМ: КОМИКС



Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Марин Ле Пенээс Frexit эхлүүлэх магадлал

Францын үндсэн хуулиар гадаад бодлого, батлан хамгаалах салбарт Ерөнхийлөгч илүү эрх мэдэлтэй. > 10

Офицеруудыг "Бүдүүн Леонард"-ын хэрэгт яллав

Хэрэгтнүүдэд хувийн эрх ашгийнхаа төлөө нэр төр, үүрэг хариуцлагаа худалдсан хэрэг тулгав. > 10

Sharp-ийг өөрчилсөн ноёнтон

Гол асуулт бол Sharp үргүй зардлаа танаснаас цааш хэтэрсэн үү гэдэг юм. > 10

Өглөгийн эзэд боловсролд анхаарлаа чиглүүлж байна

◀1

Ноён Чэн 2013 онд компанийн тэргүүнийхээ албыг шилжүүлсэн юм.

Түүний тайлбар нь автоматжуулалт зэрэг ажлын байрыг орлодог технологи ядуурлын шалтгаан болж байна гэх гэсэн хэрэг биш. "Технологийг сөрөх ямар ч арга байхгүй" хэмээн тэрбээр нэмж тайлбарласан. Шуурхай өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд ажил хийх ирээдүйг нь бүрдүүлэх үүднээс хүмүүст боловсрол олгох хүчин чармайлтаа хоёр дахин ихэсгэх хэрэгтэй хэмээн ноён Чэн үзэж байна.

Тэрбээр энэ бүхнийг эцэс болгох зорилгоор боловсролын салбарт шинэ санаачилга, шинэлэг судалгааг дэмжих жил тутмын шагналыг 7.7 сая ам.долларын сантайгаар үндэслэн байгуулжээ. Ирээдүйн чиг хандлагыг таах аргагүй болж буй өнөөгийн нөхцөлд инновацийн хүчин чадалд түлгуурлах нь түүний гол философи юм.

Дэлхийн шагнал үүсгэх санаа түүнд шөнө, унтаж байхад нь төржээ. Тэрбээр даруйхан босоод тэмдэглэлийн дэвтэртээ: "Шашин, арьс өнгө, үндэс угсаанаас үл хамаарах шагнал бий болгох. Орчлон ертөнц, хүн төрөлхтөнд хувь нэмэр болж чадах бүхнийг хөхиүлэн дэмжих" хэмээн бичсэн байна.

Эдүгээ хэдийнэ 325 сая ам.долларын хандив цуглаад буй шагналыг И-Дань Шагналын сангаас (Yidan Prize Foundation) олгож, ил тод байх үүднээс бие даасан траст сан эрхлэн хөтөлнө. Неврологийн шинжлэх ухаан хүүхдийн сургалтад хэрхэн тус болох, дэлхийн шилдэг сургуулиудаас сул сургуулиудад хэрхэн дэмжлэг үзүүлэх зэрэг сонирхолтой олон санаан дундаас шилдгийг нь энэ оны есдүгээр сард анх удаа шалгаруулж шагнах тухай ноён Чэн тайлбарласан юм.

И-Дань шагнал дэлхий нийтийг хамарснаараа ихэвчлэн



Жэк Ма 2017 онд Хөдөөгийн багш нарт олгодог Ма Юнь шагнал гардуулах ёслолын үеэр

дотооддоо чиглэж ирсэн Хятадын филантропуудын бусад шагналаас ялгарч байна. Шанхайд байрладаг Hurun судалгааны хүрээлэнгийн тооцоог үзвэл, Хятадын шилдэг 100 филантропоос буяны үйлсэд өргөсөн хандив 2016 онд 50 хувиар өсөж, 4.6 тэрбум ам.долларт хүрсэн нь тус улсын баячуудын өгөөмөр зан эрс ихэссэний илрэл боллоо. Учир нь уг үзүүлэлт ердөө гуравхан жилийн өмнө тав дахин бага байсан юм.

Гэхдээ л эрс өссөн энэ хэмжээ АНУ, Европтой харьцуулахад даруухан. Жишээ нь, АНУ-ын Bill and Melinda Gates Foundation 2015 онд 4.2 тэрбум ам.долларыг буяны үйлсэд зориулсан нь Хятадын топ 100 филантропоос өнгөрсөн онд хандивласан мөнгөтэй дангаараа тэнцэж байна.

Өөр бусад ялгаа ч бий. Өрнөдөд гол филантропуудын хандивладаг зарим хөрөнгө шашин, анагаахын судалгаа, адгуус амьтны халамжид чиглэдэг. Харин Хятадад хандивын гол хэсэг нь боловсрол олгоход чиглэдэг. Өнгөрсөн онд тус улсын шилдэг 20 буянтнаас хандивласан хөрөнгийн тал нь боловсролын салбарт зориулагдсан талаар Hurun хүрээлэнгийн судалгаанд дурджээ.

Энэ нь зарим талаар күнзийн сурталд үнэнч Хятад орны уламжлалтай холбоотойг Hurun Report-ийн захирал Руперт Хугверф тайлбарлав. "Боловсрол нь итгэл төрүүлмой. Итгэл нь найдвар төрүүлмой. Найдвар нь амгаланг төрүүлмой" хэмээн эртний Хятадын гүн ухаантан сургасан түүхтэй.

Боловсролыг эрхэмлэх явдал нь нөгөө талаар Хятад орны ядуурал, аймшиг дүүрэн цаг үеийг үзэж өнгөрөөгсөд. Ийм ч учраас өөрсдийн туулсан бүхнийг шинэ үеийнхэн нь үл үзэх нөхцөл бүрдүүлэхсэн гэж байгаа хэрэг" хэмээн ноён Хугверф өгүүлсэн юм.

Хятадын буяны үйлс бараг цоо шинээс эхэлснийг бодолцох аваас, дэлхийн хоёр дахь гол эдийн засаг 2016 World Giving Index-ийн жагсаалтад тун доогуур буюу 140-р байранд орсны учрыг ойлгож болно. Уг индексийг Charities Aid Foundation байгууллага дэлхийн улсуудыг буяны үйлсэд зориулсан зардал болон бусад үзүүлэлтэд тулгуурлан гаргадаг.

Ойрын жилүүдэд БНХАУ-аас буяны үйлсэд зарцуулах хандивын хэмжээ АНУ-ынхад дөхөж ирнэ хэмээн ноён Хугверф үзэж байна. Үүний гол хөдөлгөгч хөшүүрэг нь хөрөнгийн хуримтлал. Өнгөрсөн онд хятад тэрбумтны тоо 568 хүрсэн нь 535 хүрсэн АНУ-ын урд гарсан хэрэг юм.

Буяны үйлсэд анхаарлаа хандуулж буй тэрбумтны нэг нь цахим худалдааны Alibaba-г үндэслэгч Жэк Ма. Тэрбээр 2014 онд нөхдийн хамтаар 50 сая ам.доллар нийлүүлэн буяны сан байгуулсан нь эдүгээ хэдэн тэрбум ам.долларын хуримтлалтай болжээ. Жэк Магийн сан хөдөөгийн болон ядуу бүс нутаг дахь хүүхдийн боловсролыг дэмжих үүднээс өнгөрсөн онд анх удаа 100 багшид 1.57 сая ам.долларын тусламж үзүүлсэн. "Нутаг орчныхоо боловсролын суурийг тавигчид болох хөдөөгийн багш нарыг нэн тэргүүнд дэмжих ёстой" хэмээн ноён Ма өмнөд Хятадын Хайнань аралд болсон шагнал гардуулах ёслол дээр мэдэгдсэн юм.

Ноён Чэн ч боловсролд анхаарч өөрийн байгуулсан, ашгийн бус хувийн их сургууль болох Уханий коллежид 615 сая ам.доллар хандивлажээ. Уг их сургууль эдүгээ 11 мянган оюутантай. FT

Гэмт хэрэгтнүүд интернэтийн боломжийг алдахгүй



Изабелла Каминска

"Шинэ санаачилга" гэдэг үгийн гарал зүй нь 1540 оны тэртээх Латин хэлний "Innovatus" бөгөөд "шинэ зүйл танилцуулах" гэсэн утгатай. Үгийн үндсээс харвал шинэ санаачилга гэдэг заавал сайн, эсвэл муу зүйлийг хэлнэ гэсэн тайлбар алга. Гэтэл өнөө цагт энэ үгийг ихэвчлэн эерэг утгаар ойлгодог. Гэвч зөвхөн энэ утгаар нь ойлгоно гэдэг өрөөсгөл явдал юм.

Энэ дэлхийн хамгийн их шинийг санаачлагчид бол гэмт хэрэгтнүүд гэдгийг ямар ч цагдаа хэлнэ. Гэхдээ тэдний санаачилга нийгэмд тустай байх нь ховор. Иймч учраас сайн санаачилга муугаасаа ялгагдах хэрэгтэй. Санхүүгийн технологи хурдтай дэлгэрч байгаа нь үүний илрэл. Үүнийг финтек ч гэж хэлдэг. Финтекийн санаачлагчид технологио улам сайжруулж, санхүүгийн үйлчилгээг хялбар, илүү ихийг багтаасан, басхүү өрсөлдөөнтэй болгож буй. Ингэхийн сацуу төлбөрийн нөхцөл ч таатай болж ирлээ. Төлбөрийн үнэгүй систем дижитал санхүүгийн гэмт хэрэгтэй хамт хөгжиж байгаа нь гэмт хэрэгтнүүд илүү хурдтай санаачлагчид гэдгийг харуулж байна. Ямартай ч одоогоор финтекүүд "кримтек-криминал технологи"-той эн тэнцүү түвшинд байгаа нь салбарынхны толгойн өвчин болжээ. Ялангуяа гүйлгээний мөнгө угаах асуудал нэлээд түгшээж буй аж. Цахим худалдаа, гар утасны аппликэйшн хууль ёсны жижиглэнгийн интернэт худалдаачдад хэчнээн их хэмнэлт авчирсан. Дараа нь тэднийг мөнгө угаадаг ертөнцөд оруулсан. Хуучин цагийн мөнгө угаагчид хууль бус ашгаа угаахын тулд биетээр оршин тогтнож фронт-бизнес явуулах гэж толгойгоо гашилгадаг байв. Харин өнөө цагийн цахим гэмт хэрэгтнүүдэд хуурамч вэб хуудас юм уу түнш байхад л хангалттай. Эцэст нь хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа интернэт худалдаачдаар дамжуулан хууль бус гүйлгээ хийнэ.

Банк, худалдан авагч, хөндлөнгийн хүмүүст энэ төрлийн фронт бизнесийг олж тогтооход маш хүндрэлтэйг санхүүгийн аюулгүй байдлын мэргэжилтнүүд хэлдэг. Тэр тусмаа гүйлгээний мөнгө угаадаг арга өндөр үнийн дүнтэй гүйлгээг олон хуваах замаар хууль ёсны харагдуулдаг байна.

Төлбөрийн зөвлөх First Annapolis-оос хоёрдугаар сард хийсэн судалгаагаар хууль бус бараа, үйлчилгээ хүргэдэг цахим хуудас нийт вэбсайтын 10 хувийг эзэлж буй. Үүнийг хялбарчилж өгч байгаа зүйл бол тоо нь олширсон төлбөрийн платформ, төлбөр төлөлтийг хялбаршуулсан загвар, бүртгүүлэхэд амар хялбар байдал зэрэг юм.

Энэ аргаар мөнгө угаахад зардал бага учраас цахим гэмт хэрэгтнүүдэд хэдхэн л саад тотгор бий. Финтекийн салбар эдгээр болон бусад асуудалд гарц шийдэл олж чадна гэдэгтээ бат итгэлтэй байгаа. Exiger-ийн санхүүгийн гэмт хэргийг мөрдөх ажлын зөвлөх Лиза Осовский энэ нь амаргүйг хэллээ. Энэ төрлийн ажиллагаа эцэстээ нэмэлт төлбөр төлөх, түвэгтэй байдалд хэрэглэгчдийг оруулдаг. Энэ нь эргээд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд ачаа болдог ажээ. Тэрбээр "Үүдний жижүүр хийхэд зардал ихтэй шүү дээ" хэмээсэн байна.

Одоогоор байж болох хамгийн хямд арга бол баталгаажуулалт, хувийн мэдээллийг ацаглаж, түүнийг хөндлөнгийн хөгжүүлэгчдэд өгөх. Гэвч энэ салбарын компаниуд өсөн үржиж байхад хянагчдыг хянах хариуцлага хэний нуруунд байгаа нь анхаарал татаж байна. FT

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.



Марин Ле Пенээс Frexit эхлүүлэх магадлал

Майкл Стотард

Тавдугаар сард болох Францын сонгуульд хэт барууны хүчний удирдагч Марин Ле Пен ялах аваас евро төдийгүй Европын холбоонд сүйрлийн аюултай хэмээн хөрөнгө оруулагчид түгшиж байна. Судалгааны санал асуулгын дүнгээс үзвэл, хатагтай Ле Пен сонгуулийн сүүлийн шатанд ялагдал хүлээхээр байгаа ч дэмжигчдийнх нь тоо өссөөр. Хөрөнгө оруулагчид авлагаа борлуулж буйтай уялдан Францын бондын өгөөж сайжирсаар.

Энэ хүн Ерөнхийлөгчөөр сонгогдвол амласнаа биелүүлэхийн тулд Францыг Европын холбооноос гаргаж, еврогоос татгалзан, тус холбоотой харилцах шинэ харилцааг тодорхойлох санал хураалт явуулна хэмээн гишүүн улсууд болгоомжлох боллоо.

Хатагтай Ле Пен ингэхэд Европын холбоог дотроос нь эрс шинэчилж чадах юм биш байгаа? Франц нь Европын холбооны гол гишүүн учраас евро, иргэдийн чөлөөт шилжилт, тус холбооны хууль зүйтэй холбоотой шинэчлэл өрнүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадна хэмээн Үндэсний фронт намын удирдлага үздэг. “Франц бол Их Британи, Гректэй адилгүй, Европын холбоог үндэслэгч гишүүн улс. Хөлөө чанга дэвсээд орхивол бусад нь сонсох л хэрэгтэй” хэмээн тус намын удирдагчийн нэг өгүүлэв.

Франц-Европын холбооны харилцааг хатагтай Ле Пен үндсээр нь өөрчилж дөнгөнө гэсэн таамгийг зарим нь доог тохуу болгодог. Ийм хүмүүс Brexit-ийн өмнөхөн Их Британи ямар ч шинэчлэл өрнүүлж чадалгүй өнгөрснийг эш татаж, нэгдмэл бүсийн валют, хүмүүсийн чөлөөтэй шилжих эрхийг эцэс болгох гэсэн Үндэсний фронтын санаачилга хэт эрс шинжтэйг цохон дурдаж байна.

Европын холбооны түншүүд нь тус холбоог бутаргах хүсэлгүй тул Франц улс гишүүнчлэлээсээ татгалзахын тулд бүх нийтийн санал хураалт явуулах хэрэг гарна.

Тэгэхээр хатагтай Ле Пен “Frexit”-ийн санал хураалт явуулж таарах уу? Боломгүй зүйл биш ч тун хүчир ажил. Франц орон үндсэн хуульдаа “Бүгд найрамдах улс нь Европын холбооны нэг хэсэг” гээд заачихсан. “Frexit” өрнүүлэх гэвэл эхлээд үндсэн хуулиа өөрчлөх хэрэгтэй. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах саналыг Ерөнхийлөгч бус, Засгийн газраас оруулах ёстой гэсэн заалт 89-р зүйлд бичээстэй. Энэ нь парламентын дээд, доод танхимаар дамжсаны дараа бүх нийтийн санал хураалт явуулах, эс бөгөөс парламентын гишүүдийн 60-аас доошгүй хувийн санал авч байж бүтэх ажил.

Иймд Ерөнхийлөгч Ле Пен бүх нийтийн санал хураалт явуулахын тулд зургадугаар сарын сонгуулиар тодрох гишүүдийн олонхын санал авах шаардлагатай болж байна. “Ле Пен үнэмлэхүй олонхын санал авахгүй бол бүтэхгүй” хэмээн Саарландын их сургуулийн хуулийн ухааны профессор Филипп Коссальте тайлбарлав. Үндэсний фронт нам зургадугаар сард Парламентын доод танхимын 577 суудлын ядаж 289-ийг авах шаардлагатай. Эдүгээ тус нам доод танхимд хоёрхон суудалтай. Парламентын дээд танхим – Сенатын 348 суудлын эздийн талыг нь энэ оны есдүгээр сард сонгоно. Гэтэл сенатад тус нам мөн л хоёр суудалтай.

“Ле Пен хоёр танхимд олонх болж чадахгүй бол Европын холбооноос гарах санал хураалт явуулах аргагүй” хэмээн Citigroup-ийн эдийн засагч Гийом Менуэт тайлбарлав. Үндэсний фронт нам өөдрөгөөр тооцвол парламентад ихдээ л 100 суудал авна хэмээн тэрбээр таамаглаж байна.

Хатагтай Ле Пенд өөр арга байж болох уу? Францын үндсэн хуулийн 11-р зүйлд Ерөнхийлөгч санаачлан бүх нийтийн санал хураалт явуулж болох заалт бий. Онолын хувьд, уг заалт үндсэн хуулийг өөрчилж чадахгүй. Гэхдээ 1962 онд Шарль де Голль 11-р зүйлийн заалтад тулгуурлан санал хураалт явуулж үндсэн хуулийг өөрчилж чадсан тохиолдол бий.

Хатагтай Ле Пен чухам энэ аргыг ашиглана хэмээн Үндэсний фронтын бусад удирдлага тайлбарласан. Гэтэл санал хураалт явуулахын тулд Үндсэн хуулийн шүүхээс зөвшөөрөл авах ёстой 61-р зүйл нэмэх замаар хожим нь уг заалтыг хязгаарлаж орхисон юм. Хатагтай Ле Пен 11-р зүйлийг хэрэгжүүлэх гэвэл “Францын үндсэн хуулийн шүүхтэй нүүрэлдэх” хэрэг гарна хэмээн Oddo-ийн ахлах эдийн засагч Бруно Кавальер тайлбарлав. Шүүх ийм саналд хориг тавих магадлал их гэдгийг тэрбээр нэмж өгүүлсэн юм.

Өөр юусан билээ? Хатагтай Ле Пен бүх нийтийн санал хураалт явуулж дөнгөлөө гэхэд Францын ард түмэн еврогоос салмааргүй байгаагаа илэрхийлсэн дүнтэй төгсөж мэдэх. Eurobarometer-ийн аравдугаар сарын судалгаанаас үзвэл, францчуудын 53 хувь нь еврог “улс оронд хэрэгтэй”, 37 хувь нь “хэрэггүй” эд гэсэн бодолтой байжээ.

Тэр цагаас хойш хатагтай Ле Пен уг хандлагыг өөрчлөхөд хүчин зүтгэл гаргасаар ирлээ. Тэрбээр евро гарч ирснээр хэрэглэгдэхээ больсон “экю”-тай (European Currency Unit) төстэй мөнгийг, Францын франктай зэрэгцүүлэн хэрэглэх саналтай. Гэтэл энэ арга нь эцэстээ мөнгөний нэгдмэл холбоог бутаргахаас цаашгүй.

Хатагтай Ле Пен ялах л юм бол, үндсэн хуулийн өөрчлөлтөөс үл хамааран санхүүгийн зах зээлд уналт үүсэх аюултайг зарим шинжээч тайлбарлаж байна. Хатагтай сонгогдвол зах зээл хямарч, банкуудаас хөрөнгө гадагш урсаж болзошгүйг Citigийн шинжээч Харвиндер Сиан анхааруулав.

Санал хураалтад Марин Ле Пен ялагдал хүлээвэл яах вэ? Европын холбооноос гарах санал хураалтад ялагдвал албан тушаалаасаа огцорно хэмээн хатагтай мэдэгдсэн. Еврогоос татгалзах нь түүний эдийн засгийн бодлогын цөм. Ханшийг нь унагасан франк тус улсын ажилчдын өрсөлдөх чадвараг сайжруулна хэмээн тэрбээр үздэг.

Ле Пений дотоод бодлого ямар байх бол? Францын үндсэн хуулиар гадаад бодлого, батлан хамгаалах салбарт Ерөнхийлөгч илүү эрх мэдэлтэй. Харин улс орныг удирдан хөтлөх өдөр тутмын үйл хэрэгт, Ерөнхийлөгчийн шийдвэр нь ихэнхдээ парламентын зөвшөөрөлтэйгөөр хэрэгждэг.

Тэгэхээр парламентын дэмжлэггүй нөхцөлд хатагтай Ле Пен дүрвэгчдийн урсгалыг хязгаарлах, цагдаагийн хүч хэрэглэх гэх мэт олон эрс арга хэмжээгээ хэрэгжүүлж чадах эсэх нь эргэлзээтэй. Дэлхийн II дайнаас хойших Францын түүхэнд парламент нь Ерөнхийлөгчөө эсэргүүцсэн тохиолдол Франсуа Миттеран, Жак Ширакийн үед гурвантаа тохиолдож байжээ.

FT

Офицеруудыг “Бүдүүн Леонард”-ын хэрэгт яллав

Контр-адмиралыг оролцуулаад АНУ-ын тэнгисийн цэргийн хүчний есөн офицер сексийн үйлчилгээ, ширхэг нь 2000 ам.долларын үнэтэй коньяк, 150 килограммын жингээсээ болоод “Бүдүүн Леонард” гэгдэх болсон хахуульч гэрээлэгчтэй холбоотой авлигын хэрэгт буруутан боллоо.

Контр-адмирал, тэтгэвэрт гарах хугацаанаасаа өмнө арав-дугаар сард Тэнгисийн цэргийн хүчний тагнуулын албаны захирлын албанаас огцорсон, 48 настай Брюс Лавлесс нь Сан Диегогийн тойргийн шүүхээс мягмар гарагт гаргасан ялын төлөвлөгөөн дэх дээд албаны офицеруудын жагсаалтыг тэргүүлж байна.

Лавлесс тэргүүтэй офицеруудыг “Бүдүүн Леонард” буюу Леонард Гленн Фрэнсисээс тансаг дайллага, дээд зэрэглэлийн зочид буудал, янхан хүүхний үйлчилгээ авч, хариуд нь тэнгисийн цэргийн нууцын зэрэглэлтэй мэдээ материалаар хангаж байсан хэрэгт татжээ. Сингапурт байрладаг батлан хамгаалах үйлдвэрлэлийн гэрээлэгч Леонард Фрэнсис нь Ази дахь АНУ-ын Тэнгисийн цэргийн офицеруудад хээл хахууль цутгаж, ажил хэргээ явуулдаг байв.

Түүний Glenn Defense Marine Asia компани 25 жилийн тэртээгээс АНУ-ын тэнгисийн цэргийн хүчинд үйлчилж иржээ. Ноён Леонард өгөөмөр төлбөр авах замаар Ази дахь АНУ-ын байлдааны хөлгүүдэд чиргүүл онгоцноос эхлээд шатахуун, цэвэр ус хангамж, хог хаягдал зайлуулах үйлчилгээг хүртэл жижиг гэлтгүй хариуцан гүйцэтгэдэг байсан юм.

Ялын төлөвлөгөөнд, Леонард болон хамсаатнууд нь 2004 оноос хойш арав гаруй жилийн турш АНУ-ын тэнгисийн цэргийн хүчнээс “Олон арван сая доллар”-ын илүү төлбөр авсныг тайлбарлажээ. “Фрэнсисийн буяныг хүртдэг” офицерууд хариуд нь түүний компанид хэрэг болохуйц тэнгисийн цэргийн үйл ажиллагаа, маневртай холбоотой хаалттай мэдээллэд нэвтрүүлж, байлдааны хөлгүүдийг ашигтай гэсэн боомтуудад нь хуваарилдаг байсныг ялын тогтоолд өгүүлсэн байна.

Хонконгийн Викториагийн булан дахь Petrus ресторанд 2006 оны хоёрдугаар сард зохион байгуулсан зоог 20345 ам.доллар болсоныг өгөөмөр эзэн төлсөн нь ердөө ганц жишээ. Жилийн дараа Манилын боомтын ойролцоох, Дэлхийн II дайны үед генерал Дуглас Макартур амьдарч байсан тансаг буудалд ноён Фрэнсис офицеруудыг өндөр үнэтэй архинд булхуулсан өргөн цэнгээн зохион байгуулжээ. Ялын тогтоолд дурдсанаас үзвэл, тэнгисийн цэргийн хүчний баатрын нэрээр нэрлэсэн пентхаусын тавдугаар давхарт байрласан офицерүүд янхан хүүхнүүдийн хамт наргиж өнжсөн ажээ.

Ялын тогтоолд чөлөөнд гарсан дөрвөн офицерын нэр бий. Үүнд Долдугаар флотын командлагчийн арын албаны ажилтан хариуцсан тэргүүн байсан, 60 настай Дэвид Ньюлэнд; Kitty Hawk байлдааны хөлгийн засвар үйлчилгээ хариуцсан офицер байсан, 56 настай Доналд Хорнбек, логистикийн офицер байсан, 58 настай Жэймс Долан; Abraham Lincoln байлдааны хөлгийн засвар үйлчилгээ хариуцсан офицер байсан, 62 настай Дэвид Лосман нар. Үүнээс доод тушаалын дөрвөн офицерт “Бүдүүн Леонард”-ын бүлгийн хамсаатан гэсэн ял тулгажээ.

“Хэрэгтнүүдэд хувийн эрх ашгийнхаа төлөө нэр төр, үүрэг хариуцлагаа худалдсан хэрэг тулгаж байгаа”-г АНУ-ын Ерөнхий прокурорын шоронгийн хэрэг эрхэлсэн туслах Кеннет Бланко мэдэгдлээ. Авлигын хэрэгт Тэнгисийн цэргийн хүчний 20 офицер, Glenn Marine компанийн таван ажилтныг буруутгасан. Үүнээс 13 нь ноён Фрэнсисийн хамт хэдийнэ ял хүлээгээд байгааг АНУ-ын Хууль зүйн яам тайлбарлав.

Нийт 70 байлдааны хөлөг, 200 гаруй нисэх онгоц, 40 мянган усан цэрэгтэй Долдугаар флот нь АНУ-ын Тэнгисийн цэргийн хүчний гол бүрэлдэхүүн юм.

FT



Sharp-ийг өөрчилсөн ноёнтон

Кана Инагаки



Foxconn 2016 онд Sharp-ийг 3.5 тэрбум ам.долларaар худалдан авсны дараа тус компанийн ерөнхийлөгчөөр томилогдсон Тай Жен-Ву корпорацийн соёлыг “чинээлэг айлын хүү”-гийн сэтгэлгээтэй адилхан болголоо. Sharp компанийг удирдсан долоон сар гаруйн хугацаанд ноён Тай мөнгө зарцуулах зуршлыг нь даруй хатуу чанд болгов. Тэрбээр 26 мянган ам.долларaас дээш бүх зардлыг гардан зогсоосон байна. Тэр ч бүү хэл хоёр машины зогсоолыг үзэсгэлэнгийн танхим болгоотохжээ. Ноён Тай бизнес хийх бүх арга чаргыг өөрөө хяналаа.

Үүний үр дүн нь сахилга баттай хөрөнгө оруулалт, борлуулагч болон хэрэглэгчидтэй хийх гэрээ хэлцлийг хатуу хянаснаар Sharp-ийг санхүүгийн хүнд байдалд оруулсан хүчин зүйлсийг өөрчлөх аж.

Шүүмжлэгчид харин ноён Тайг АНУ болон Хятадад хавтгай дэлгэцийн үйлдвэр барих Foxconn-ий төлөвлөгөөнд Sharp хэрхэн оролцох талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөнгүй хэмээн шүүмжилжээ. Мөн энэхүү хөрөнгө оруулалтын хэд нь Foxconn-ийг үүсгэн байгуулагч Тэрри Гугийн халааснаас гарах нь ч тодорхойгүй байна. Гэсэн хэдий ч хэрээс хэтэрсэн зардлыг танаснаар Sharp-ийн орлого аль хэдийнэ нэмэгджээ. Найман улирал дараалж алдагдал амссан тус компани 2016 оны сүүлийн улиралд 37 сая ам.долларын ашиг олоод буй. Түүнчлэн Sharp-ийн хувьцаа Токиогийн хөрөнгийн биржийн жижиг түвшний хэсэг рүү зэрэг буусан. Гэвч ноён Тай 2016 оны наймдугаар сард ерөнхийлөгч болсноос хойш бараг дөрөв дахин өсчээ.

Гол асуулт бол Sharp үргүй зардлаа танаснаас цааш хэтэрсэн үү гэдэг юм. Ноён Тай бодитой хэд хэдэн өөрчлөлт хийсэн. Тэд зөвхөн япон хэлээр л бусадтай харилцаж, сар бүр ажилтнуудаа “One Sharp” гэх уриа бүхий захидал илгээдэг байна. Гэсэн хэдий ч Sharp-ийн сэтгэлгээг бүрэн засварлаж чадсан, эсэхдээ итгэлгүй байгаагаа тэрбээр сэтгүүлчидтэй хуваалцжээ. АНУ болон Европын зах зээлд эзлэх байр сууриа хэрхэн тэлэх тухай бодитой менежментийн бодлого боловсруулах хэрэгтэй. Интернэтийн эрин зуунд Sharp-ийн дэлгэц, гэрийн электрон бараа амжилттай байх, эсэхэд хөрөнгө оруулагчид эргэлзэж байгаа.

Sharp-ийн хэд хэдэн удирдах албан тушаалтан компаниа орхиж, Apple-ын нийлүүлэгч Японы Nidec тэргүүтэй компанид орсон. Гэвч ноён Тай үүнд санаа зовнихгүй байгаа ажээ. Эцсийн эцэст Sharp санхүүгийн хүнд байдалд орсон нь тэдний буруу учраас тэр гэнэ.

Ноён Тай Sharp-ийн өндөр албан тушаалтнуудад төвлөрсөн цалингийн системийг өөрчлөх амлалтаар залуу ажилтнуудын итгэлийг хүлээх хүсэлтэй. Энэ нь авьяаслаг ажилтнууд нас, хүйс, үндсээс үл хамааран цалингаа нэмүүлж, тушаал дэвших боломжтой болно гэсэн үг. Мөн компанийн борлуулалт, ашгийг нэмсэн ажилтнуудад “ерөнхийлөгчийн тусгай шагнал” гээчийг өгөхөөр төлөвлөж байгаа аж.

FT

Эдийн засаг

ГАДААД ХУДАЛДАА

Эрдсийн экспорт 57.3 хувиар өсчээ

Б.Баярмагнай
Шинжээч

Монгол Улс оны эхний хоёр сард 727.7 сая ам.долларын эрдэс бүтээгдэхүүн экспортолжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 57.3 хувиар өссөн болохыг Үндэсний статистикийн хорооноос мэдээлэв. Гадаад худалдааны ашиг нэмэгдэхэд эрдэс бүтээгдэхүүний экспорт голлон нөлөөлсөн. Ялангуяа нүүрсний экспорт биет хэмжээ болон үнийн дүнгээр өссөн нь нийт эрдэс бүтээгдэхүүний экспортыг дэмжжээ.

Манай улс 4.8 сая тонн нүүрсийг 327.3 сая ам.долларааар экспортолсон. Энэ нь өмнөх оны мөн үеэс биет хэмжээ нь 3.5 дахин, үнийн дүнгээр найм дахин нэмэгдсэн үзүүлэлт.

Харин алт болон зэсийн баяжмалын экспорт буурсан байна. Мөн 1.1 сая баррель түүхий газрын тосыг 58.5 сая ам.долларааар борлуулжээ. Дэлхийн зах зээлд газрын тосны үнэ ханш харьцангуй өссөн нь биет хэмжээ буурсан ч үнийн дүн нь өмнөх оноос өсөхөд нөлөөлсөн байна. Мөн цайрын хүдэр баяжмалын экспортыг онцолж болно. Биет хэмжээ нь өмнөх оны мөн үеэс 8000 тонноор өсөж, үнийн дүн нь гурав дахин нэмэгджээ. Ингэснээр 26.9 сая ам.долларт хүрсэн гэж албаныхан мэдээлэв.

ТЕХНОЛОГИ

"Teams" үйлчилгээ нэвтрүүлэв

"Microsoft" корпораци компаниудын дотоод хэрэгцээнд зориулсан харилцаа холбооны "Teams" үйлчилгээг нэвтрүүллээ. Энэ нь тус компанийн "Office", ялангуяа "Outlook" програмтай хослон ажиллах аж.

"SAP" корпорацитай хамтран нэвтрүүлсэн энэ үйлчилгээ нь "Slack Technologies" болон "HipChat"-ийн платформтой өрсөлдөх зориулалттай ажээ. Нийт 181 зах зээлд нэвтэрсэн "Microsoft"-ийн "Teams" үйлчилгээг "Expedia", "Alaska Air" групп зэрэг "Office 365" үйлчилгээний 50 мянга гаруй аж ахуйн нэгж хэрэглэж эхэлсэн талаар тус компаниас мэдээллээ. Аялал, жуулчлалын зуучийн үйлчилгээ үзүүлдэг "Expedia"-ийн мэдээллийн технологийн 300 ажилтан "Teams"-ийг ашигладаг болохыг онцолжээ.

Түүнчлэн "Atlassian" корпорацийн "Trello" платформыг ашигладаг компаниуд "Trello"-оос өгөгдлүүдээ шууд "Teams" рүү холбох боломжтой юм байна.

УУЛ УУРХАЙ

"Chalco"-гийн өр нимгэрч байна



С.Батсайхан / ЗГМ©

Өрийн үлдэгдэл 56 сая ам.доллар болжээ

◄1

Түүнээс хойш нүүрсний үнэ унаж, Монголын хар алтны үнэлгээ буурснаар өр барагдуулах хугацаа сунаж өнөөдөртэй золгоод буй юм. "Эрдэнэс Тавантолгой" компанийн тухайд Баруун цанхиас олборлосон нүүрсээ зах зээлд борлуулдаг. Харин Зүүн цанхийн нүүрсээр "Chalco"-гийн өрийг барагдуулж байгаа.

Тэрчлэн энэ сарын эхээр тус компани Цанхийн баруун уурхайн уулын ажлын гүйцэтгэчийг сонгож, "Монгол уурхайчид" түншлэл шалгарчээ. Уулын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг нээлттэй зарласан бөгөөд "Монгол уурхайчид" буюу "Хишиг Арвин Индустриал", "Олборлолт", "Мера" компанийн хамтарсан түншлэл тодорсон байна.

Төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" компани энэ оны хоёрдугаар сарын эхээр Цанхийн зүүн, баруун уурхайгаас 800 мянган тонн орчим нүүрс борлуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс хоёр дахин өссөн үзүүлэлт аж. Компани энэ онд 11.5 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн. Нүүрсний экспортын хэмжээнээс гадна ханшийг өсгөхөөр зорьж байгаа. Энэ оны нэгдүгээр сард Баруун цанхийн нүүрсийг тонн тутмыг нь 71.5 ам.долларааар нийлүүлсэн. Энэ нь Монголын нүүрсний зах зээлийн түүхэн дэх хамгийн өндөр үнэд тооцогдож байна. Өөрөөр хэлбэл, сүүлийн таван сарын хугацаанд ханшийг 165 хувиар өсгөжээ.

Харин Зүүн цанхийн нүүрсний үнийг индекс тооцох аргачлалын дагуу зах зээлтэй уялдуулдаг. Өнгөрсөн оны дөрөвдүгээр улиралд 32.94 ам.доллар байсан үнэ энэ оны нэгдүгээр улиралд 59.33 ам.доллар болж өсөөд байгаа юм.

» Гэрээ ёсоор өр төлбөрийг цэглэсний дараа Тавантолгойн Зүүн цанхиас олборлож буй нүүрсний багагүй хувийг "Chalco"-д нийлүүлнэ.

» Цанхийн баруун уурхайн уулын ажлын гүйцэтгэгчээр "Монгол уурхайчид" түншлэл шалгарчээ.

» Энэ онд багтан өр төлбөрөө барагдуулснаар санхүүгийн дарамтаас чөлөөлөгдөнө. 2018 оноос олон улсын зах зээлд IPO хийж, хөрөнгө оруулалт татахаар төлөвлөж буй.

Үнийн өсөлт компанийн санхүүгийн байдалд эергээр нөлөөлсөн. Тиймээс энэ онд өр төлбөрөө цэгцлэхээр зорьж буйгаа удирдлагууд нь дуулгасан. Тодруулбал, нүүрс худалдах, худалдан авах тухай "Chalco" компанитай байгуулсан хамтын ажиллагаанаас гадна 2015 онд TTJVCo компанитай олборлолтын гэрээ байгуулсан. Олборлолтоос үүдэлтэй өрийг ч ойрын хугацаанд барагдуулах зорилго тавин ажиллаж байна.

Ийнхүү энэ онд багтан өр төлбөрөө барагдуулснаар санхүүгийн дарамтаас чөлөөлөгдөнө. Улмаар 2018 оноос олон улсын зах зээлд IPO хийж, хөрөнгө оруулалт татахаар төлөвлөж буйгаа "Эрдэнэс Тавантолгой" компанийн удирдлагууд мэдээлэв. Цаашид зам тээвэр, цахилгаан станц зэрэг бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалтад төвлөрч ажиллахаар зэхэж байгаа ажээ. [ЗГМ]

АЖ ҮЙЛДВЭР

Хүнд үйлдвэрийн төслүүд урагшилна

Т.Элиса
Шинжээч

"Southgobi Sands" компани энэ оны эхний улиралд Овоот Толгойн уурхайд түшиглэн нойтон технологиор нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Тус үйлдвэрт эхний ээлжинд 800 мянган тонн нүүрс баяжуулна. Гурав дахь жилээс 3.2 сая тонн болгон нэмэгдүүлнэ гэж "Southgobi Sands" компаниас мэдээллээ. Түүнчлэн МАК компани Хөх цавын цементийн үйлдвэрээ мөн энэ улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Тус үйлдвэр жилд нэг сая тонн цемент боловсруулах хүчин чадалтай аж. Үүнээс гадна Гацууртын ордын төслийг энэ онд урагшлуулахаар төлөвлөж буйг Сангийн яамнаас мэдээлсэн юм.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хүнд үйлдвэрийн дөрвөн том төслийг онцолж байна. Нүүрснээс нийлэг хий гаргах үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-ийг ирэх дөрөвдүгээр сард багтаан боловсруулна. Уг үйлдвэрийн бүтээн байгуулалтад дөрвөн жил шаардлагатай гэсэн тооцоо гарчээ. Мөн Дархан-Сэлэнгийн бүсэд байгуулах хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ирэх долдугаар сард бэлэн болгоно. Түүнчлэн газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийг Энэтхэг улсын зээлээр байгуулахаар болоод байгаа юм. Үүнээс гадна "Оюутолгой"-д түшиглэсэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл хүлээгдэж байна.

МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛ

МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛ ОУВС-ГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭЛЭЛЦЛЭЭ

Улаанбаатар хот – Монголын Бизнесийн зөвлөл (МБЗ) 3-р сарын 13-ны өдөр сар бүрийн ээлжит уулзалт хэлэлцүүлгийг "ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ӨСХ) ба хувийн хэвшилд үзүүлэх нөлөөлөл" сэдвээр Бэст Вэстерн Туушин зочид буудалд амжилттай зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг эдийн засагч Д.Жаргалсайхан хөтөлж, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, ОУВС-гийн Монгол дахь суурин төлөөлөгч Нэйл Сэйкэр, Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Жэймс Андерсон нар оролцогчдын асуултад хариулав.

Хэлэлцүүлгийн үеэр ОУВС-гийн Монгол дахь суурин төлөөлөгч Нэйл Сэйкер ӨСХ нь Стэндбай хөтөлбөрөөс удаан хугацаанд үргэлжилж харьцангуй бага буюу 2 хувийн хүүтэй байх тухай онцлон тэмдэглэв. Мөн тэрээр хөтөлбөр хэрэгжих хугацаанд төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх, төсвийн тогтвортой байдлын хуульд заасан хэмжээнд хүргэх нь хөтөлбөрийн зорилго гэв.

Түүнчлэн Дэлхийн Банкны суурин төлөөлөгч Жэймс Андерсон эдийн засгийн суурь үзүүлэлтийг сайжруулахын тулд төсөв хэтрүүлсэн зардлыг зогсоож, шударга тайлан тооцоо



гаргах нь реформын эхний алхам болохыг тэмдэглэв.

2009 онд Монголбанк эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрийг ОУВС-тай хамтран хэрэгжүүлсэн туршлагатай. Энэ удаагийн хөтөлбөрт хамрагдсанаар зээл нэмэгдүүлэх гэхээсээ илүү зээлийн бүтцийн өөрчлөлт хийж байгааг Монголбанкны Дэд ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн онцоллоо.

Эдийн засагч Д.Жаргалсайхан "Өнөөгийн эдийн засаг хүндрэлтэй үед Засгийн газар иргэд, хувийн хэвшлийн үгийг сонсоно. Бид өөрсдийн дуу хоолой, шаардлагаа зогсолтгүй илэрхийлсээр байх ёстой" гэв.

Мөн уулзалтаар Австрали Улсаас Монгол Улсад суугаа Бүрэн эрхт элчин сайд Жон Лангтри тус улсын Засгийн газраас санхүүжүүлсэн "Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр"-ийг товч танилцуулсан ба уг хөтөлбөрт хамрагдсан 20 орчим төгсөгч уулзалтад оролцсон юм.

Хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудад тулгамдаж буй асуудал хэлэлцэх, хамтран шийдэл олох, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж бий болгох мөн цаг үеийн мэдээллээр хангах зорилготойгоор МБЗ сар бүрийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулдаг билээ.

БИЗНЕСИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТЭРГҮҮНИЙ ТҮНШ
www.bcmongolia.org
Утас: 976-11-317027/70114442
Ц-шуудан: info@bcmongolia.org

ЗГМ ТОВЧХОН

» ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

72.2

Хувь. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд хоёрдугаар сарын эцэст 47.2 мянгад хүрчээ. Үүний 34.1 мянга буюу 72.2 хувийг нь бүртгэлтэй ажилгүй, үлдсэн нь ажилтай боловч өөр ажил хайж буй иргэд эзэлж байна.

» ХӨДӨӨ АЖ АХУЙ

133.9

Мянга . Том малын зүй бус хорогдол оны эхний хоёр сард улсын хэмжээнд 133.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 258 мянгаар буурав.

» ДААТГАЛ

34

Хувь. Нийгмийн даатгалын сангийн орлого өнгөрсөн сард өмнөх оны мөн үеэс 63.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Тэтгэврийн даатгалын сангийн орлого 57 тэрбум төгрөг буюу 34 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

» ТЕХНОЛОГИ

45

Швейцарийн тансаг зэрэглэлийн бугуйн цаг үйлдвэрлэгч "Tag Heuer" компани "Intel" болон "Google"-тэй хамтран "Connected Modlar 45" ухаалаг цагны шинэ загварыг танилцууллаа.

» ТҮҮХИЙ ЭД

47

Ам.доллар. West Texas төрлийн газрын тосны ханш 2.7 хувиар суларч, 47 ам.доллартай тэнцлээ.

1200

Ам.доллар. Алтны ханш 0.1 хувиар чангарч, унци нь 1200 ам.долларыг давав.

» ХӨРШ

8.9

Хувь. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарыг чиглэсэн хөрөнгө оруулалт өнгөрсөн сард 8.9 хувиар буурсан байна.

6.3

Хувь. Хятадын аж үйлдвэрийн гарц оны эхний хоёр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.3 хувиар өссөн байна. Энэ нь "Bloomberg"-ийн шинжээчдийн таамгаас 0.1 хувиар өндөр өсөлт.

» ДЭЛХИЙД

5


Хувь. БНСУ-ын ажилгүйдлийн түвшин өнгөрсөн сард 0.1 хувиар өсөж, таван хувьд хүрсэн байна. Ингэснээр долоон жилийн дээд цэгт хүрлээ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2458.38
Евро	2615.22
Япон иен	21.35
ОХУ рубль	41.69
БНХАУ юань	355.30
БНСУ вон	2.14

Эдийн засаг

АНУ, Азийн хувьцааны ханш уруудлаа



Японы Topix индекс сүүлийн нэг сард (нэгжээр)

Дэлхийн зах зээлд хүчтэй нөлөө үзүүлдэг АНУ-ын Холбооны нөөцийн банкны мөнгөний бодлогын шийдвэр хүлээгдэж байна. Шинжээчдийн зүгээс Америкийн төв банкны удирдлагууд бодлогын хүүгээ өсгөнө гэж таамаглаж байгаа. Гэхдээ олон улсын зах зээлд ам.доллар болон Америкийн хувьцааны ханш унаж байна. "Bloomberg"-ээс тооцдог ам.долларын спот индекс 0.2 хувиар доошилжээ. Өмнө нь тус индекс 0.3 хувиар өсөөд байв.

Үүнээс үүдэн тус улсын худалдааны гол түнш Азийн хувьцааны ханш уруудлаа. Тухайлбал, Японы Topix индекс 0.2 хувиар буурлаа. БНСУ-ын Kospi индекс ч төдий хувиар багасчээ. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО
99903584, 99903581


МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	60.83	▲ +2.24%	3/15/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.035	▼ -14.63%	3/15/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	20	▼ -8.05%	3/15/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.023	▼ -4.17%	3/15/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	3/15/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4.3	▲ +0.94%	3/15/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.11	▼ -3.52%	3/15/2017
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.35	▼ -12.5%	3/15/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.205	▼ -4.65%	3/15/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.7	▼ -1.41%	3/15/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ ($)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1204.37	▲ +0.09%	3/15/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	944.4	▲ +0.59%	3/15/2017
МӨНГӨ	SIA	унци	16.96	▲ +0.22%	3/15/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	264.3	▲ +0.3%	3/15/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	89.27	▲ +1.4%	3/15/2017
WTI ТОС	CLA	баррель	48.51	▲ +1.66%	3/15/2017
БРЕНТ	COA	баррель	51.63	▲ +1.39%	3/15/2017
БЕНЗИН	XBA		159.98	▲ +1.03%	3/15/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.929	▼ -0.31%	3/15/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	344	▼ -0.32%	3/15/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	81.95	▲ +1.17%	3/15/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.181	▼ -0.11%	3/15/2017
БУДАА	RRA	центнер	9.76	▲ +0.26%	3/15/2017
БУУДАЙ	WA	бушель	433.75	▲ +0.75%	3/15/2017
КАКАО	CCA	тонн	2058	▲ +2.03%	3/15/2017
КОФЕ	KCA	фунт	1.412	▼ -0.77%	3/15/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүсэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	347	▲ 5.08%	3/15/2017
ГОВЬ ХК	GOV	12830	▼ -3.97%	3/15/2017
МАХ ИМПЕКС ХК	MMX	2420	▼ -3.74%	3/15/2017
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	20500	◀▶ 0%	3/15/2017
СҮҮ ХК	SUU	132	▲ 1.38%	3/15/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	20120	▲ 0.6%	3/15/2017
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	2397	▲ 0.76%	3/15/2017
БАГАНУУР ХК	BAN	1786	▼ -1.33%	3/15/2017
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК	ETR	99.98	▲ 0.08%	3/15/2017
ХӨХ ГАН ХК	HGN	63	◀▶ 0%	3/15/2017
ГЕРМЕС ЦЕНТР ХК	HRM	140.05	▼ -5.37%	3/15/2017
ЖЕНКО ТУР БЮРА ХК	JTB	51.16	▲ 0.31%	3/15/2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	532.56	▼ -6.4%	3/15/2017
МОНГОЛ НЭХМЭЛ ХК	MNH	4018	▼ -10.71%	3/15/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	390	▲ 1.78%	3/15/2017
МОННООС ХК	MNS	1600	▼ -2.97%	3/15/2017
МЕРЕКС ХК	MRX	90	▲ 2.27%	3/15/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5856.816	-18.97	▼ -0.32%	3/15/2017
DAX INDEX	DAX	11988.79	-1.24	▼ -0.01%	3/15/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15379.61	-165.21	▼ -1.06%	3/15/2017
S&P/ASX 200	AS51	5773.997	+14.86	▲ +0.26%	3/15/2017
S&P 500	INX	2365.45	-8.02	▼ -0.34%	3/15/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3239.663	+0.34	▲ +0.01%	3/15/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	20837.37	-44.11	▼ -0.21%	3/15/2017
TOP 20	MSETOP	13023.73	-54.96	▼ -0.42%	3/15/2017
FTSE 100	UKX	7357.85	-9.23	▼ -0.13%	3/15/2017
HANG SENG	HSI	23795.64	-32.31	▼ -0.14%	3/15/2017
NIKKEI 225	NKY	19577.38	-32.12	▼ -0.16%	3/15/2017



Mongolia Forbes

ШИНЭ ДУГААР ХУДАЛДААНД ГАРЛАА
ТҮГЭЭЛТИЙН БҮХ САЙН ЦЭГҮҮДЭЭР

Хаяг: Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

sales@forbesmongolia.mn | Утас: 77074646